

БАЙГАЛЬ ОРЧНЫ ЯАМ
Цөлжилттэй тэмцэх үндэсний хороо



"Ган, цалжилтад ноцтой нэрвэгдэж буй орнуудын болон
ялангуяа Африкийн цөлжилттэй тэмцэх тухай НҮБ-ийн
конвенц"-ийн хэрэгжилтийн талаарх

ҮНДЭСНИЙ ТАЙЛАН

Цөлжилттэй тэмцэх конвенцийн 2000 оны Талуудын
деревдүгээр бага хурал

Улаанбаатар
2000

Байгаль орчны яам

Нийгэлүүлэхийн төслийн төсөлдээр
Байгаль орчны яамын төслийн төсөлдээр
Байгаль орчны яамын төслийн төсөлдээр

Цөлжилттэй тэмцэх үндэсний хороо

Засгийн чар

Д. Доржсүрэн, БОЯ, ГЭБА

Н. Зоригсүрэн, БОЯ

Н. Саралтуяа, БОЯ

Б. Ганбет, БОЯ, ГЭБА

Д. Цэвэгдоржицоо, БОЯ, УРУУШ

“Ган, цөлжилтэд ноцтой нэрвэгдэж буй
орнуудын болон ялангуяа Африкийн цөлжилттэй
тэмцэх тухай НҮБ-ийн конвенцii”-ийн
хэрэгжилтийн талаарх

ҮНДЭСНИЙ ТАЙЛАН

Цөлжилттэй тэмцэх конвенцийн 2000 оны Талуудын
дөрөөдүгээр бага хурал

A handwritten signature in blue ink, appearing to read "D. Ganbets".

Улаанбаатар

2000

Энэхүү тайланг бичих, орчуулах, хэвлэхэд Монгол улсын
Байгаль орчны яам, <<Хөгжил, орчил төв>>ТББ, Байгаль орчны
<<ЭЗО-АЗИ>> дээд сургууль хүн хүчиний болон техникийн
тусслалцаа, НҮБ-ийн Цэлжилттэй тэмцэх конвенцийн Нарийн бичгийн
дарга нарын газар санхүүгийн дэмжлэг үзүүлэв.

Нийт жедээсэн бэлэн дэлжилж, нийт
жетижилж ийхээсээ хувьтаслаа нийт жедээсэн
ийх-тээвэрээх ийх-ийн хувьтаслаа
хувьтаслаа нийтийн төсөх

НАРНЯТ ЙННСӨДНҮ

нээгдээж ындоо 9005 иймийнээсээж хөгжлийн
Copyright © 2000, Байгаль орчны яамны зөвшөөрлөөр дахин
хэвлэнэ.

цэвэршилт

9005

ЦТК-ийн анхны тайлан бэлтгэсэн багийн гишүүд

Хянан тохиолдуулсан :

Зохиогчид:

Ч.Адъяасүрэн Боржигдхан, ЦТК,
ЦТҮХ-ийн үндэсний зохицуулагч
Ч.Адъяасүрэн Боржигдхан, БОЯ
Н.Эрдэнэсайхан, БОЯ
Н.Сарантуяа, БОЯ
Б.Ганбат, БОЯ, ГЗБА
Д.Цээсдролцоо, БОЯ, УЦУОШ
Л.Нацагдорж, БОЯ, УЦУХ
Л.Жанчидорж, ШУА, Геоэкологийн
хурээлэн (ГЭХ)
Д.Даш, ГЭХ
Д.Аваадорж, ГЭХ
Х.Жалбаа, ГЭХ
Ч.Доржсүрэн, БОЯ, БОХА, ОАТ
Б.Хулдорж, МХ-21
Г.Энхтайван, БОЯ
Ж.Осоржамаа, БОЯ
Б.Биньеz, ХААУЯ
С.Хөдөлмөр, БОЯ, МТТ
Д.Энхсайхан, БОЯ
Р.Мижиддорж, "ЭКОС" ХХК
А.Намхай, "Хөгжил орчин төв" ТББ
С.Сангидансранжав, "САТУ" ХХК
М.Энхбаяр, Д.Гансүх
Н.Эрдэнэсайхан, БОЯ
П.Цэнд-Аюуш, И.Баярмаа

Орчуулагчид:

Англи хэлний редактор:

Хэвлэлд бэлтгэсэн:

ТОВЧИЛСОН НЭР ТОМЬЁО

УИХ-	Улсын их хурал
ЗГ-	Засгийн газар
БОЯ-	Байгаль орчны яам
ХААУЯ-	Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яам
БОХА-	Байгаль орчныг хамгаалах алба
ГЗБА-	Газар зохион байгуулалтын алба
УЦУОШГ-	Ус, цаг уур орчны шинжилгээний газар
БОШТЛ-	БОЯ-ны Байгаль орчны шинжилгээний төв лаборатори
БОТХ-	Байгаль орчны төрийн хяналт
УЦУХ-	БОЯ-ны Ус цаг уурын хүрээлэн
УЦУОШТ-	Ус цаг уур, орчны шинжилгээний төв
МТТ-	БОЯ-ны Мэдээлэл тооцооны төв
БХЭТ-	БОЯ-ны Багаж хэмжил зүйн төв
ДГТ-	БОХА-ны Дархан газрын товчоо
ТХГН-	Тусгай хамгаалалтай газар нутаг
ОАТ-	БОХА-ний ОЙ, ангийн товчоо
МУИС-	Монгол улын их сургууль
УБИС-	Улсын багшийн их сургууль
ХААИС-	Хөдөө аж ахуйн их сургууль
МЦХК-	Монголын цахилгаан холбоо компани
ЦТК-	Цөлжилттэй тэмцэх конвенц
ЦТК НБДГ-	ЦТК-ийн нарийн бичгийн дарга нарын газар
ЦТУХ-	Цөлжилттэй тэмцэх үндэсний хетелбер
ЦТУХор-	Цөлжилттэй тэмцэх үндэсний хороо
СХС-	Сэдэвчисэн хетелберийн сүлжээ
MX-21-	Монголын төвортой хөгжлийн хетелбер-21 /MAP-21/
НҮБ-ын ХХААБ-	НҮБ-ийн Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага /FAO/
НҮБХХ-	Нэгдсэн үндэстний байгууллагын /НҮБ/ Хөгжлийн хетелбэр (UNDP-ЮНДП)
НҮБ-ын АНДЭЗНК-	НҮБ-ын Ази номхон далайн эдийн засаг нийгмийн комисс
НҮБ БОХ-	НҮБ-ын Байгаль орчны хетелбэр /UNEP-ЮНЕП/
НҮБ ЮНСО-	НҮБ-ын Ган, цөлжилттэй тэмцэх алба /UNSO-ЮНСО/
ДДБОС-	Даян дэлхийн байгаль орчны сан /GEF/
ДБХС-	Дэлхийн байгаль орчны сан /WWF/
ТАСИС-	Европын холбооны ТАСИС
ДБ-	Дэлхийн банк /WB/

АХБ-	Азийн хөгжлийн банк /ADB/
ДАНИДА-	Данийн хөгжлийн агентлаг /DANIDA/
ЖАЙКА-	Японы олон улсын хөгжлийн агентлаг /JICA/
МБОХХ-	Монголын байгаль орчныг хамгаалах холбоо
ХОТ-ТББ	Хөгжил, орчин төв, ТББ /D&E/
"Эко-Ази"-	Байгаль орчны "ЭКОАЗИ" дээд сургууль
НОАА-	АНУ-ын Далай, агаар мандлыг судлах газар /NOAA/
AVHRR-	Ялгах чадвар илүүтэй сайжруулсан радиометр
TOVS-	"Тайрос" маягийн дагуулаас (цаг уурын үзэгдлийг) өндөрт шуурхай хэмжилт хийх
ГМС-	Газар зүйн мэдээллийн тогтолцоо /GIS/

**Цэлжилттэй тэмцэх конвенцийн хэрэгжилтийн
талаарх үндэсний тайлан**

1. АГУУЛГА	6
2. ХУРААНГУЙ	9
3. ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР, БОДЛОГЫН ХҮРЭЭНД ТОГТООСОН СТРАТЕГИ, АЧ ХОЛБОГДЛЫН ЗЭРЭГЛЭЛ	13
3.1. Нийгэм здийн засгийн бусад стратеги, хөтөлбөр.	13
3.1.1. Үндэсний хөгжлийн төлөвлөгөө	13
3.1.2. Байгаль орчны үйл ажиллагааны хөтөлбөр.	14
3.1.3. Үндэсний болон орон нутгийн тогтвортой хөгжлийн хөтөлбөр.	14
3.2. Цэлжилттэй тэмцэх тухай НҮБ -ын конвенциос емне боловсруулсан цэлжилттэй тэмцэх стратеги, төлөвлөгөө	15
4. КОНВЕНЦИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛГООР АВСАН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ	16
4.1. Үндэсний зохицуулах байгууллага, үндэсний зохицуулагчийн үүрэг	16
4.1.1. Эрх зүйн орчин	16
4.1.2. Нөөц боломж	16
4.1.3. Үйл ажиллагааны загвар, бүрэлдэхүүн.	18
4.1.4. Мэдээ, мэдээллийн байдал	19
4.2. Үндэсний зохицуулах байгууллагаас цэлжилтийн байдалд байнга хяналт тавих бүтэц, зохион байгуулалт	19
4.3. Үйл ажиллагааны үндэсний хөтөлбөр нь үндэсний здийн засаг, нийгмийн хөгжлийн болон байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний нэг хэсэг мен	19
4.3.1. Үндэсний хөтөлбөрийг байгаль орчны болон бусад стратеги, төлөвлөлтийн тогтолцоотой уялдуулах нь.	19
4.3.2. Цэлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг үндэсний хөгжлийн хандлагатай уялдуулах нь.	21
4.3.3. Цэлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг дэд бусийн үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулах нь.	21
4.3.4. Засгийн газрын зөвшөөрөл.	22
4.4. Эрх зүйн уялдаа, холбоо бүхий зохицуулах тогтолцоо хийх нь	23
4.4.1. Байгаль орчны хууль тогтоомжинд дүн шинжилгээ	23
4.4.2. Газрын шинэлгээл	24
5. ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ БОЛОВСРУУЛЖ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД	

ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦОО	26
5.1 Ундэсний хэмжээний асуудлын зэрэглэлийг тогтооход оролцогчтaluудын үр нөлөөг дээшлүүлэх нь	26
5.1.1 Уулзалт, зөвлөлгөөн арга хэмжээнд олон нийтийн төлөөллийг бий болгох арга	27
5.1.2 Ундэсний хэмжээний арга хэмжээний зэрэглэлийг тогтооход оролцогч талуудын төлөөлөл	28
5.1.3 Мэдээлэл, боловсрол, харилцааны төрөл	29
5.1.4 Хамтран ажиллах, харилцан ойлгох зэрэглэл	30
6. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ БОЛОВСРУУЛЖ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗӨВЛӨЛДӨӨНИЙ ҮЙЛ ЯВЦ БА ХӨГЖИНГҮЙ ОРОН - ТАЛУУД БОЛОН СОНИРХСОН БУСАД БАЙГУУЛЛАГУУДТАЙ БАЙГУУЛСАН ТҮНШЛЭЛИЙН ГЭРЭЭ	32
6.1. Олон улсын түншүүдийг үйл ажиллагаанд оролцуулах талаар Засгийн газраас авсан арга хэмжээ	32
6.1.1. Засгийн газраас авсан арга хэмжээ	32
6.1.2. Засгийн газраас цаашид явуулах үйл ажиллагаа	35
6.2. Түнш орнуудын хоорондын үйл ажиллагааны талаар албан бус зөвлөлдөх ба зохицох үйл ажиллагаа явуулах	36
7. ГАН, ЦӨЛЖИЛТИЙН МОНИТОРИНГ ХИЙХ, ҮНЭЛГЭЭ ӨГӨХ ЗОРИЛГООР ЦӨЛЖИЛТТЭЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ТҮҮНИЙ ДОТОР ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧНЫГ САЙЖКРУУЛАХ, БАЙГАЛИЙН БАЯЛГИЙГ ХАМГААЛАХ, ТОГТВОРТОЙ АШИГЛАХ, БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ, ЦӨЛЖИЛТ, ТҮҮНД ХЯНАЛТ ТАВИХ МЭДЛЭГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР ТӨЛӨВЛӨСӨН БОЛОН АВЧ ХЭРЭГЖҮҮЛС ЭН АРГА ХЭМЖЭЭНҮҮД	37
7.1.Өмнөх туршлагын оношлогоо	37
7.1.1. Монгол орон дахь цөлжилтийн өнөөгийн байдал	37
7.1.2. Цөлжилтийн хүчин зүйл	38
7.1.3. Цөлжилттэй тэмцэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний үнэлгээ	40
7.2. Цөлжилттэй тэмцэх техникийн хөтөлбөрүүд ба хэрэгжиж буй цогцолбор төсөл.	41
7.2.1. ЦГҮХ-ийн хурээнд хэрэгжиж буй бусад чиг бодлого, хөтөлбөрийн төрлүүд, тэдгээрийн үр дүн.	41
7.2.2. Цөлжилттэй тэмцэх үндэсний чадавхийг бэхжүүлэх талаарх арга хэмжээ	43
7.3. Үйл ажиллагааны хөтөлбөрүүдийн конвенцийн заалтад нийцэх нь.	45

7.3.1. Цөлжилттэй тэмцэх бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгож байгаа нь	45
7.3.2. Ган, цөлжилттэд хяналт шинжилгээ хийх, үнэлгээ өгөх арга хэмжээ	46
7.3.3. ЦТУХ-ийг хэрэгжүүлэхийн тулд эдийн засгийн орчныг сайжруулах арга хэмжээ	46
7.4. Дэд бүс, бүсийн хамтын ажиллагааны хетелберүүдтэй уялдаа нь	46
7.5. Орон нутгийн чадавхи буй болгох арга хэмжээний үр дүн	47
7.6. Түншлэлийн гэрээнүүд	47
 8. ЦӨЛЖИЛТТЭЙ ТЭМЦЭХ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ДЭМЖИН ҮНДЭСНИЙ ТӨСВӨӨС ХУВААРИЛСАН САНХҮҮЖИЛТИЙН ХЭМЖЭЭ, ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА ХИЙГЭЭД САНХҮҮГИЙН БОЛОН ТЕХНИКИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА, САНХҮҮЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛ, АЧ ХОЛБОГДЛЫН ЗЭРЭГЛЭЛ	49
8.1 Хэрэглэж байгаа санхүүгийн механизм	49
8.1.1 Улсын төсвийн санхүүжилтийн эх үүсвэр, орон нутгийн оролцогч талуудад олгож байгаа нь	49
8.1.2 Гадаад, дотоодын нөөц бололцоог дайчлах арга, механизм	50
8.1.3 Хуурай гандуу нутгийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын дүн шинжилгээ	52
 9. ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦЫГ ТОДОРХОЙЛОХОД АШИГЛАСАН ШАЛГУУР БОЛОН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ТАЛААРХИ ТОЙМ	53
9.1 Байгаль орчны мониторинг, үнэлгээний шуурхай механизмын 9.1.1 Байгаль орчны мониторингийн үндэсний чадавхийг бэхжүүлэх нь	53
9.1.2 Цөлжилттэй тэмцэх мэдээллийн сан	56
9.1.3. Одоо байгаа механизмын, бүтэц, тогтолцоог нийцүүлэх арга хэмжээ	60
9.1.4. Гол оролцогч талуудын мэдээлэл олж авах боломж	60
9.1.5. Дун шинжилгээний үр дүнг зөвлөлдөх механизмын	60
9.1.6. Тогтмол тайлагнах байдал	61
9.1.7. ЦТУХ-ны менежментийн талаар гаргах санал	61
 10. ХАВСРАЛТ	63
11. АШИГЛАСАН ХЭВЛЭЛ	64

ХУРААНГҮЙ

Монгол улс 1992 оноос эхлэн Цөлжилттэй тэмцэх конвенцийг хэрэгжүүлэх зорилгоор Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрөө /ЦТҮХ/ боловсруулж эхэлсэн болно. Хөтөлбөрийг 1996 онд Засгийн газрын 169 дүгээр тогтоолоор сайшаав. Хөтөлбөрт нь цөлжилтэнд хүргэж байгаа байгаль, хүний нөлөөллийн шалтгааныг тогтоож, цөлжилттэй тэмцэх байгаль, нийгэм, эдийн засгийн хүчин зүйлийг үнэлж үзсэн юм.

ЦТҮХ нь З үе шаттай хэрэгжихээр төлевлөгдсөн. Эхний үе шатанд төв болон орон нутгийн төр захиргаа, териин бус байгууллага, оролцогч талуудын хэлхээ холбоог бэхжүүлэх, төвлөрлийг сааруулах бодлого зохицуулалт хийх, эрх зүйн орчин бурдүүлэхэд голлон анхаарна.

Дунд үе шатанд цөлжилтэд мониторинг тавих чадавхи бурдүүлэх, цөлжилтэд хүчтэй нэрвэгдэж буй газрыг тодруулах, цөлжилтийн эрч хүчийг сааруулах, суулчийн үе шатанд ЦТҮХ-ийг нийт үндэсний хэмжээний чадавхи болгон бэхжүүлнэ.

ЦТҮХ-ийг "Монгол улсын ХХI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр (MX-21), түүнчлэн нийгэм, эдийн засгийн хөгжлийн болон байгаль орчны бусад хөтөлбөрүүдтэй уялдаатайгаар боловсруулж, мөн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Монгол Улсын Их Хурал 1996 оны 8 дугаар сарын 22-нд "Ган, цөлжилттэй тэмцэх НҮБ-ийн конвенцд"(ЦТК) нэгдэн орох шийдвэр гаргаж, мөн оны 12 дугаар сарын 26-нд энэхүү шийдвэр хүчин төгөлдөр болж, Монгол улс конвенцид нэгдэн орсон 42 дахь орон болов.

ЦТК-ийг хэрэгжүүлэх үндэсний зохицуулах байгууллагын үүргийг Монгол Улсын Байгаль орчны яам, түүний дэргэд ажиллаж байгаа Цөлжилттэй тэмцэх үндэсний хороо/ЦТҮХор/ гүйцэтгэдэг.

ЦТҮХороог териин болон Төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээ, хувийн хэвшил, олон нийтийн нөлөөлөл

оролцсон үндэсний семинарын үеэр илээр санал хураах журмаар байгуулж, ЦТК-ийн үндэсний зохицуулагчийг сонгосон болно.

ЦТҮХорооны хаяг:

Улаанбаатар -11

Бага тойруу – 44

Засгийн газрын байр – 3

Өрөөний дугаар: 518, 415

Утас/факс: 976-1-322830, 312320

E-mail: adyasurents@usa.net.

ЦТК-ийг хэрэгжүүлэх болон ЦТҮХ-ийг боловсруулах зорилгоор 1995, 1997 онд Үндэсний хэмжээний семинар, уулзалтыг зохион байгуулсан юм. Семинарын үеэр Монгол орны ган, цөлжилтийн телев байдалд үнэлгээ, дүгнэлт өгч хөтөлбөрийн гол үзэл санааг тохиролцсон юм.

Монгол орны нутаг дэвсгэрийн 41.3 хувь говь целийн бүсэнд багтаж байна. Нийт газар нутгийн 78.2 хувь нь цөлжилтэнд өртөх боломжтой, үүнээс 59.4 хувь нь цөлжихэд нэн эмзэг нутаг юм. Одоогоор бэлчээр нутгийн 70 гаруй хувь нь доройтол, эзлэгдэлт ороод байна. Нийт нутгийн дэнгэж 8.3 хувийг ой бүхий газар эзэлнэ. Цөлжилтэд хургэж буй гол шалтгаан нь байгалийн болон хүний үйл ажиллагаатай холбоотой гэж үздэг.

Цөлжилттэй тэмцэхийн тулд юуны урьд ЦТҮХ-ийг боловсруулж, түүнийг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх арга хэмжээг авч байна.

ЦТҮХ нь дотроо 20 төслийг багтаасан бөгөөд тэдгээрийг богино, дунд, урт хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн юм.

Дотоодын санхүүгийн неөц боломж, гадаадын тунш, хандивлагчдын тусламж дэмжлэгтэйгээр хөтөлбөр хэрэгжиж байна.

Ялангуяа ЦТҮХ-ийн эхний үе шатны зорилтууд болох цөлжилттэй тэмцэхэд оролцогч талуудын хэлхээ холбоог бэхжүүлэх, төвлөрлийг сааруулах арга хэмжээ амжилттай хэрэгжиж байна. ЦТК, ЦТҮХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт хийж, төв, орон нутагт газрын харилцаа, зохион байгуулалтын асуудал хариуцсан албадыг байгуулан, цөлжилт, газрын доройтолын явцад хяналт тавьж байна.

Мөн газар зохион байгуулалтыг боловсронгуй болгох, газрын

доройтолыг сааруулах, цөлжилттэй тэмцэх шууд холбоо бүхий газрын харилцааны болон байгаль орчныг хамгаалах, зохистой ашиглах харилцааг зохицуулсан 20 гаруй хууль, 200 орчим журам, актыг УИХ, ЗГ-аас батлан гаргаж мөрдөж эхэллээ.

Ой, ус, тусгай хамгаалалттай нутаг, биологийн төрөл зүйл, байгалийн гамшгийн аюулыг бууруулах, хог хаягдлыг бууруулах, Байгаль орчны мэдээлэл сурталчилгаа, агаар хамгаалах зэрэг асуудлыг хамарсан тусгай хөтөлбөрүүд боловсруулж, ЦТҮХ-тэй уялдаатайгаар хэрэгжүүлж байна. Түүнчлэн ЦТҮХ нь "Үндэсний хөгжлийн үзэл баримтлал", "Төрөөс экологийн талаар баримтлах бодлого", "Байгаль орчны үйл ажиллагааны хөтөлбөртэй" нягт уялдаатай боловсрогдон, хэрэгжиж байна.

ЦТҮХ болон дээрхи төрөлжсөн хөтөлберийг боловсруулах, хэрэгжүүлэх уулзалт, семинар, хурал, зөвлөлгөөний явцад / 1995, 1997, 1998, 1999/ ХАА, ой, газар зохион байгуулалт, усны аж ахуй, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, боловсрол, шинжлэх ухаан, дэд бүтэц зэрэг Засгийн газрын байгууллага, төрийн бус байгууллага болон эмэгтэйчүүд, залуучуудын төлеөлөл оролцож санал бодлоо илэрхийлэх, тэдний хүчийг дайчлах, хамтран ажиллах талаар нилээд ахиц дэвшил гарч байна.

ЦТҮХ-ийн хүрээнд газрын харилцааны эрх зүйн үндэс бүрдэж, ЦТҮХ-ийг хэрэгжүүлэхэд үндэсний төсвийн тодорхой хэсгийг зарцуулах механизм бий болсноор орон нутгийн хүн ам оршин суугаа нутгийнхаа байгалийн нөөц, газрын баялагaa хамгаалах, тогтвортой ашиглахад тэдний оролцоо дээшилж, аж амьдралаа сайжруулах боломжтой боллоо.

Негеэ талаар цөлжилтөөс сэргийлэх, газар зохион байгуулалтыг сайжруулах талаар гарах төрийн бодлого боловсруулахын ёмне олон түмэн, нутгийн иргэдээс санал авах, хэлэпцүүлэгт хийх, тэдгээрийн санал, хүсэлтийг тусгах механизм тогтох эхлээд байна. Олон нийт, нутгийн оршин суугчидтай харилцахдаа радио, телевиз, сонин хэвлэл ашиглах, тусгай танилцуулга бэлтгэж санал авах, интернетын сүлжээ ашиглах, вэб хуудас нээх, ТББ-аар дамжуулан ажиллах зэрэг олон хэлбэрийг ашиглаж байна.

ЦТК-ийг хэрэгжүүлэх талаар хэдийгээр дотоодын санхүүгийн нөөцийн боломжтой хэсгийг дайчилж байгаа боловч улсын төвлөрсөн төлөвлөгөөтэй эдийн засгаас зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж байгаа шилжилтийн үеийн бэрхшээл, хөрөнгө санхүүгийн хомсдол ихээхэн байгааг тэмдэглэх нь зүйтэй юм.

Нөгөө талаар дэлхий нийтийг хамарсан дулаарапалтын нелевеgeer хавар, намар газар нутаг хуурайшиж, олон удаа ган болж, түүнчлэн хүмүүсийн хариуцлагагүй үйл ажиллагааны уршгаар жил бүр хэдэн зуун удаа түймэр гарч үлэмж хэмжээний ой, бэлчээр нутаг нэрвэгдэж байна.

Энэ бүхэн нь ЦТК, ЦТҮХ-ийг хэрэгжүүлэхэд зарим нэг бэрхшээл учруулж байгаа боловч, конвенц, хөтөлбөрийг хэрэгжүүлэх суурь тавигдсан гэж үзэх үндэслэлтэй юм.

3. ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР, БОДЛОГЫН ХҮРЭЭНД ТОГТООСОН СТРАТЕГИ, АЧ ХОЛБОГДЛЫН ЗЭРЭГЛЭЛ

3.1. Нийгэм здийн засгийн бусад стратеги хөтөлбөр

"Монгол Улсын ХХ1 зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр" (MX-21) боловсруулж эхэлсэн түүх Бразилийн Рио де Жанейро хотноо болсон НҮБ-ын "Байгаль орчин, хөгжил" Бага хуралд Монгол улс оролцож, улмаар Даян дэлхийн 21-р зууны хөгжлийн хөтөлбөрт нэгдэн орсон үндэстнүүдийн нэг болсноос эхтэй. Энэхүү хөтөлбөрийг НҮБ-ын Чадавхи-21 сангийн санхүүжилттэйгээр 1996 оны 6-р сараас эхлэн боловсруулж 1998 онд Монгол Улсын Засгийн Газраас сайшаан дэмжсэн юм. Ийнхүү Монгол улс эдүгээз үндэсний болон орон нутгийн тувшинд боловсруулсан тогтвортой хөгжлийн стратегитай болсон билээ. Энэхүү стратегийн баримт бичигт здийн засгийн есент, нийгмийн тэгш байдал, байгалийн неөөцийн зохист хэрэглээ гураваас бүрдсэн хөгжлийн стратеги тусгагдсан болно. Мен хөтөлбөрт Монгол улсын нийгэм здийн засаг, байгаль орчны өнөөгийн байдалд үнэлэлт өгсний сацуу үндэсний хөгжлийн зорилт болон тэргүүлэх чиглэлийн хүрээг тодорхойлж тэдгээр зорилгод хүрэх арга зам, тохиолдож болох бэрхшээлийг давах зарим хувилбар тусгагдсан болно.

3.1.1. Үндэсний хөгжлийн төлөвлөгөө. MX-21 - ийн 14 дүгээр бүлэг Монгол орны цэлжилтийн өнөөгийн байдал, хэтийн хандлагад үнэлэлт өгөөд цэлжилттэй тэмцэх зорилт, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлсны дээр Монгол орны цэлжилтийн ерөнхий чиг хандлагыг Монгол орны цаг уурын өөрчлөлтийн хэтийн загварчлалын бүтцэд тодорхойлсон болно. MX - 21 - д тодорхойлсноос үзвэл Монгол орон газар зүйн байршил, байгаль цаг уурын нехцел, гадаргын хэв шинжийн хувьд ган цэлжилтийн эрсдэл бүхий, хуурай бүс нутагт хамрагддаг байна. Манай улсын нутаг дэвсгэрийн 41.3 % нь говь целийн бүсэд багтаж, 84.7 % нь 1000 метрээс дээш өргөгдөж, 40.6 % нь цайвар хүрэн, целийн борсаарал элсэн хөрс зонхилсон экотогтолцоотой ажээ.

Монгол орны хувьд цэлжилттэй тэмцэх нь экологийн аюулгүй байдал, тогтвортой хөгжил, өнөө болон хойч үеийн эрх ашгийг хөндсөн амин чухал асуудал болсныг гэрчилнэ. Цаашид ч малын too толгой өсч, газрын тосны хайгуул, алт олборлолт эрчимжин, улмаар газар, газрын хөрсний доройтол улам нэмэгдэх хандлагатай байна. Иймд байгалийн неөц баялаг хомсдох, байгалийн болон хүний нелөөгөөр цэлжилтийн аюул тэлэх явдлыг хязгаарлахад чиглэсэн өргөн хүрээтэй стратеги боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагатай боллоо.

MX - 21 - ийн хүрээнд боловсруулсан загварчлалын үр дүнгээс үзвэл 2050 - аад оны орчим говь хээрийн бүсийн эзлэх талбай одоогийнхоос 24,3 - 30,9 хувиар нэмэгдэх төлөвтэй байна. Ялангуяа

Их нууруудын хотгор, Дундговь аймгийн нутгаас Туулын тохой хүртэл өргесен хойшоо түрж болох хэтийн төлөв харагдаж байна.

Үүний зэрэгцээ цөлжилтэй тэмцэх ажлыг нийтэд хүртээмжтэй болгох үүднээс MX-21-ийн хүрээнд *"Дорноговь аймгийн Замын Үүд суманд учирч буй цөлжилттэй тэмцэх зорилгоор газрын тогтвортой менежмент нэвтрүүлэх"* туршилтын төслийг хэрэгжүүлсэн болно. Энэхүү төслийн зорилго бол орон нутгийн иргэд, олон нийтийг цөлжилтэй тэмцэх үйлст татан оролцуулж, орон нутгийн засаг захиргаа, өөрөө удирдах байгууллага, ард иргэд, бусад байгууллагуудын хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх боломжийг бодит жишээн дээр харуулах явдал байлаа.

3.1.2. Байгаль орчны үйл ажиллагааны хөтөлбөр. Байгаль орчны үйл ажиллагааны хөтөлбөрийг Дэлхийн Банкны дэмжлэгтэйгээр боловсруулж 1996 онд Засгийн Газрын 169 дугаар тогтоолоор баталжээ. Энэхүү хөтөлбөрт цөлжилттэй тэмцэх, цөлжилтээс сэргийлэх бодлого, үйл ажиллагааг газрын менежментийг сайжруулах, газрын төлбөр тогтоох, газар зохион байгуулалтад олон нийтийн оролцоог өргөтгэх тэдний оролцоотой хийхээр тусгажээ. Энэхүү хөтөлбөр нь Цөлжилттэй Тэмцэх Конвэнцтэй нэгэн зэрэг хийгдсэн учир уг конвэнцийн узэл санааг бүрэн тусгасан болно.

Үүний зэрэгцээ уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулалтынхаа төгсгелийн шатанд явж байна. Үндэсний болон бүх аймаг, нийслэл хотын хөгжлийн хөтөлбөр байгаль орчноо хамгаалах үйл ажиллагааг тусгасан бүхэл бүтэн хэсэгтэй.

3.1.3. Үндэсний болон орон нутгийн тогтвортой хөгжлийн хөтөлбөр. MX-21 - ийн боловсруулалтад терел бүрийн ажил мэргэжлийн олон зуун хүн оролцож байгаль орчны хамгаалал, байгалийн нөөцийг зохистой ашиглах, цөлжилттэй тэмцэх үйл ажиллагаатай нягт уялдаатайгаар нийгэм эдийн засгийн хөгжлийн оновчтой хувилбарыг сонгоход хувь нэмрээ оруулцаасан юм. Сонирхлын олон бүлгүүдийг хамруулсан семинар, зөвлөгөөнийг улс орны янз бүрийн бүс нутагт олон удаа зохион байгуулж хөгжлийн нийтлэг үзэл баримтлал, стратегийн амин чухал асуудлаар санал солилцон, зөвшилцэх замаар энэ ажлыг харьцангуй болгино хугацаанд гүйцэтгэсэн болно. Мен дээрхтэй агуулга, хэлбэр, үйл явцыг нийслэл хот, бүх 21 аймагт зэрэг өрнүүлснээр аймаг тус бүр Аймгийн ХХ1 зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөрөө боловсруулсныг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлууд сайшаан дэмжсэн болно. Аймаг нийслэлийн туршилагаар зарим нэгэн сумд ч үйл ажиллагааны хөтөлбөртэй болсон. Үндэсний болон орон нутгийн дээрх хөтөлбөрүүд нь

- Нийгмийн тогтвортой хөгжил

- Эдийн засгийн тогтвортой хөгжил
- Байгаль хамгаалал, байгалийн нөөцийг зохистой ашиглах (цэлжилттэй тэмцэх г.м)
- Хэрэгжүүлэх хэрэгсэл

гэсэн үндсэн дервэн хэсгээс бүрдэж байна.

Монгол улсын 21 дүгээр зууны тогтвортой хөгжлийн хөтөлберийг боловсруулах үйл явцад бүх аймгийн Засаг даргын Тамгын газар өргөн хүрээтэй, идэвхитэй оролцсон юм. Аймаг бүр Тогтвортой хөгжлийн хөтөлберөө боловсруулан гаргасны дээр үйл ажиллагааныхаа хөтөлбөрт нийцэхүйц туршилтын тесел хэрэгжүүлсэн юм. Аймгийн тогтвортой хөгжлийн зөвлөхүүд, сургалт, сурталчилгааны ажлын тусгай хөтөлбөр боловсруулан нийгмийн бүхий л хүрээний гишүүдийг хамруулсан юм. Ингэснээр "Монгол Улсын 21 дүгээр зууны Тогтвортой хөгжлийн хөтөлбөр" нь "дээрээс доош" явагддаг нэг урсгалт уламжлалт зарчмыг халж, нэгдмэл, бодит ажил болж чадлаа.

Түүнчлэн нийт 14 аймгийн хөтөлбөрт цэлжилттэй тэмцэх тодорхой үйл ажиллагаа тусгагдсан бол нийслэл хот, бүх аймгийн 21 дүгээр зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөрт газрын элэгдлээс хамгаалах, цэлжилттэй тэмцэх өргөн хүрээтэй арга хэмжээ тусгагдсан байна.

3.2. Цэлжилттэй тэмцэх тухай НҮБ -ын конвенциос өмнө боловсруулсан цэлжилттэй тэмцэх стратеги, төлөвлөгөө

Монгол улс цэлжилттэй тэмцэх талаар тухайлсан стратеги, болон төлөвлөгөөг 1994 оноос өмнө боловсруулж байсангүй. 1990-ээд оноос Монгол улс зах зээлийн эдийн засагт шилжсэнээр нийгэм, эдийн засаг, байгаль орчны бодлогыг уялдуулах эхний алхамыг хийж эхэлсэн болно. УИХ-аас 1992 онд баталсан "Монгол Улсын Үндсэн хууль" байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх талаар төр, иргэний үүргийг тодорхойлж, газрыг Монгол улсын иргэнд эзэмшүүлэх, улмаар өмчлүүлэх эрх зүйн үндэсийг баталгаажуулсан юм.

Мен 1994 онд баталсан "Хүнсний хөтөлбөр", "Эрчим хүчиний мастер төлөвлөгөө" зэрэг баримт бичигт газрыг зохистой ашиглах газрын доройтлол, хөрсний элэгдэл, цэлжилттэй сэргийлэхэд чиглэсэн шинэ агротехнологи нэвтрүүлэх арга хэмжээ тусгагдсан байна.

4.КОНВЕНЦИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛГООР АВСАН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ.

4.1.Үндэсний зохицуулах байгууллага, үндэсний зохицуулагчийн үүрэг

4.1.1.Эрх зүйн орчин. Монгол улсад Засгийн газрын хуулийн (УИХ-ын тогтоол, 1993,1996,1999 он) дагуу байгалийн нөөцийг ашиглах, хамгаалах, нехен сэргээх, түүний дотор цөлжилттэс сэргийлэх, цөлжилттэй тэмцэх бодлого зохицуулалт хийх үргийг ЦТК-ийн үндэсний зохицуулах байгууллага болох Байгаль орчны яам хулээдэг. Монгол улсын Засгийн газар 1996 оны 7-р сард "Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийг ЦТҮХ/ батлан түүнийг хэрэгжүүлэх ажлыг эхэлсэн нь НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх Конвенцийг (ЦТК) үндэсний түвшинд хэрэгжүүлэх бодит нехцел болсон юм. Түүнчлэн үндэсний хэмжээнд цөлжилттэй тэмцэх асуудлыг зохицуулах, эрх бүхий үндэсний зохицуулах байгууллага болох Цөлжилттэй тэмцэх үндэсний хороог ЦТҮХор/ Байгаль орчны сайдын 1998 оны 59 дүгээр тушаалаар байгуулав. Энэ хороо нь НҮБ-ийн Цөлжилттэй тэмцэх конвенцийг вэрийн оронд хэрэгжүүлах ажлыг зохион байгуулах, биелэлтэнд нь хяналт тавих үүрэгтэй. Тус хорооны үүрэг, бүрэн эрх нь Байгаль орчны сайдын эрхлэх ажлын хүрээнд багтдаг. ЦТҮХороо нь орон тооны бус байгууллага бөгөөд бие даасан санхүүгийн үйл ажиллагаа явуулдаггүй, зөвхөн санхүүгийн нөөцийг дайчлах, хуримтлуулах, зохицуулах, хяналт тавих эрхтэй юм. Тус хороо цөлжилттэй тэмцэх үйл ажиллагааг зохицуулах, энэ арга хэмжээнд зориулан хөрөнгө санхүүгийн нөөцийг дайчлах ажлыг зохион байгуулах болон мэргэжлийн дэмжклэг туслалцаа авах, тесел, санал боловсруулах зэрэгзэр хандивлагч орнууд, олон улсын байгууллагуудтай хамтран ажилладаг. Цөлжилттэй тэмцэх үндэсний хороо нь териийн бус байгууллагын статустай бөгөөд 11 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Үндэсний зохицуулах байгууллагын хүрээнд олон талын болон орлох чадварыг хангах зорилгоор ЦТҮХороо нь териийн ба териийн бус байгууллага, хувийн хэвшил, шинжлэх ухаан, зруул мэнд, боловсрол, нийгэм, эдийн засаг, байгаль хамгаалах, газар зохион байгуулалт зэрэг салбар мэргэжлийн ур чадвар өндөртэй ахлах мэргэжилтэн, эрдэмтдийн төлөөллөвөс бүрдсэн байна. Тус хорооны дарга нь Цөлжилттэй тэмцэх асуудлаар үндэсний зохицуулагчийн үүрэг хүлээн ажиллаж байна.

ЦТҮХороо нь Ерөнхий сайдаар толгойлуулсан тогтвортой хөгжлийн үндэсний хороотой ажлаа уялдуулан явуулдаг.

4.1.2.Неец боломж. Монголын цөлжилттэй тэмцэх үндэсний зохицуулах байгууллага болох Байгаль орчны яам нь хүн хүчний неецеөр харьцангуй хангагдсан гэж үзэж болох боловч санхүүгийн

болон материалын нөөцөөр ихээхэн дутмаг байдаг.

a)Хүний нөөц

Целжилттэй тэмцэх, байгаль орчныг хамгаалах асуудлыг тэр, засгийн бодлогын салшгүй бүрэлдэхүүн хэсэг болгон Засгийн газрын үйл ажиллагааны хетелберт тодорхой зорилтуудыг дэвшүүлэн үе шаттай хэрэгжүүлж байгаа бөгөөд энэ арга хэмжээнд улсын төсвийн зохих хувийг зарцуулж байна.

Үндэсний хорооны бүрэлдүүн, түүний харьяа байгууллагуудад газар зохион байгуулалт, ойжуулалт, ой, усны менежмент, байгаль орчныг хамгаалах, улсын тусгай хамгаалалттай газрыг хамгаалах, газрын доройтолтой тэмцэх салбарын шууд төлөөлөл байхын зэрэгцээ эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, боловсрол, эдийн засаг зэрэг салбарын төлөөлөгчид багтдаг байна. Эдгээр салбарын мэргэжилтнүүдтэй мэдээлэл солилцох, хурал семинар зохион байгуулах, засгийн газраар шийдвэрлэх асуудалд санал авах, төсөл хэрэгжүүлэхэд оролцуулах, интернет, е-майлээр харилцах зэрэг өргөн хэлбэрээр холбогдон ажиллаж байна.

Хүснэгт 1. Үндэсний зохицуулах байгууллага- Байгаль орчны яамны

Хүний нөөц, албан тушаал	Хамрах арга хэмжээний хурээ	Харьяалах байгууллага, салбар
Байгаль орчны сайд, Төрийн нарийн бичгийн дарга	Байгалийн нөөц баялгийг зохицой ашиглах, хамгаалах нахен сэргээх, байгаль орчны менежмент хийх	БОЯ,ГЗБА,БОХА, УЦУОСГ
Сайдын зөвлөх, ЦТҮХорооны дарга	ЦТК болон ЦТҮХ-ийг хэрэгжүүлэх, зохицуулах, зохион байгуулах	Үндэсний хороо, яамны салбар байгууллага
Байгаль орчныг Хамгаалах албаны Дарга, дэд дарга	Тусгай хамгаалалттай нутгийн менежмент, ой,усны менежмент, биологийн төрөл зүйлийг хамгаалах, байгаль орчны төрийн хяналт	ДГТ, ОАТ,БОТХ, орон нутгийн ДГЗ
Газар зохион байгуулалтын албаны дарга, дэд дарга	Газар зохион байгуулалт, менежмент, төлөвлөлт, газар ашиглалт	Орон нутгийн газрын харилцаны албад
Ус цаг уур, орчны шинжилгээний газрын дарга,дад дарга	Ус цаг уур, орчны мониторинг, үнэлгээ, думалт,прогноз	УЦУХ,МТТ,БХЭТ,БОШТЛ, Орон нутгийн УЦУОСТ
Үндэсний хорооны ажилттан	ЦТҮХ-ний өдөр дутмын ажил үүрэг	Дээрхи байгууллагууд

б) Санхүүгийн нөөц

ЦТҮХороо нь өврийн мэдлийн санхүүгийн эх үүсвэргүй боловч Байгаль орчны яамны хүрээнд хийгдэх арга хэмжээний зардал, тухайлбал, газар зохион байгуулалт, ойжуулалт, худаг ус гаргах, тусгай хамгаалалттай нутгийн менежмент хийх, газрыг нөхөн сэргээх, ус цаг уур орчны мониторинг хийх, байгалийн нөөц баялгийн ашигласны орлогын тодорхой хэсгийг байгаль хамгаалах болон цэлжилттэй тэмцэх арга хэмжээнд зориулах зэрэг бүхий л үйл ажиллагаанд санал өгөх, зөвлөх, зарим теслүүдийг захиалан авч хэрэгжүүлэх зэрэг арга хэмжээг өргөн ашигладаг.(Хүснэгт 2)

Цэлжилттэй тэмцэх үйл ажиллагааны санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэхэд УИХ-аас батлан гаргасан "Байгалийн баялаг ашигласны төлберийн орлогоос нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь хэмжээг тогтоох" тухай хууль (УИХ-ын хууль, 2000 он, № 18) чухал үүрэг гүйцэтгэж байна. Үндэсний зохицуулах байгууллага нь гишүүдээрээ дамжуулан тэдгээрийг төлөөлж байгаа териин ба териийн бус байгууллага, орон нутгийн засаг захиргаа, хувийн хэвшлийн байгууллага, нэгжтэй харьцаж үйл ажиллагаагаа явуулж байна.

4.1.3. Үйл ажиллагааны загвар, бүрэлдэхүүн. Байгаль орчны яам болон төрийн бусад яамд, парламентын зарим гишүүд, эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургууль, олон нийтийн байгууллага, гадаад орноос Монгол улсад суугаа ЭСЯ, олон улсын төсөл, байгууллага, орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийг оролцуулсан Цэлжилттэй тэмцэх үндэсний семирнарыг зохион байгуулах явцдаа үндэсний зохицуулах хорооны гишүүдийн нэрийг илзэр дэвшиүүлж санал хураах зарчмаар сонгож бүрдүүлсэн болно. Цэлжилттэй тэмцэх үндэсний хорооны удирдах бүрэлдэхүүн нь Зөвлөлийн дарга буюу Үндэсний зохицуулагч, түүний орлогч дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэнэ. ЦТҮХорооны 20 хувь, түүний харьяа териийн захиргааны болон судалгаа шинжилгээний байгууллагын ажилтнуудын 40-50 хувь, (Газар зохион байгуулах алба, Геоэкологийн хүрээлэн, Ус цаг уурын хүрээлэн, Мэдээлэл тооцооллын төв г.м) нь эмэгтэйчүүд байна.

Орон нутагт цэлжилтээс урьдчилан сэргийлэх, цэлжилтийг сааруулах, түүнтэй тэмцэх асуудлыг аймаг, сум, багийн Засаг дарга хариуцах бөгөөд үндэсний зохицуулах зөвлөл нь Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар дамжуулан цэлжилтийн хор хөнөөллийг олон түмэнд сурталчлах, сургалт явуулах, энэ арга хэмжээнд иргэдийг татаан оролцуулах зэргээр орон нутгийн төлөөллийн байгууллагатай хамтран ажилладаг юм. Цэлжилттэй тэмцэх үндэсний хороо нь ажлаа

жил, улирлаар төлөвлөж жилд 4-өөс доошгүй удаа хуралдах бөгөөд зарим үед эзлжит бус хурлаар шаардлагатай асуудал, төслийг авч хэлэлцэж байна. Энэ хугацаанд Цөлжилттэй тэмцэх конвенц болон цөлжилттэй тэмцэх үндэсний семинарыг 1995,1997 онуудад НҮБ-ийн Ган, цөлжилттэй тэмцэх алба ЮНСО болон Цөлжилттэй тэмцэх конвенцийн нарийн бичгийн дарга нарын газрын дэмжлэгээр Улаанбаатар хотод зохион байгуулж тулгамдсан олон асуудлыг хэлэлцэж холбогдох зөвлөмж боловсруулж гаргасан нь цөлжилттэй тэмцэхэд бүх нийтийн оролцоог хангахад үр дүнтэй арга хэмжээ болсон юм.

ЦТУ Хороо нь өөрийн ажил үүргээ байгаль орчны яамны дотоод төсвийн хүрээнд гүйцэтгэдэг. Гэвч энэ нь хүрэлцээ муутай байдаг. Цөлжилттэй тэмцэх үндэсний хорооны ажилд Байгаль орчны яамны сайдын зөвлөлөөс байнга хяналт тавьж жил бүр ажлын тайланг хүлээн авч, үнэлгээ, дүгнэлт өгч, Сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцдэг механизм тогтоод байгаа нь ихээхэн ач холбогдолтой юм.

4.1.4. Мэдээ, мэдээллийн байдал. ЦТУХороо нь гадаадын шууд мэдээлэл авах интернетийн MAGIC.NET системийг байнга ашиглах боломжтой. Дотоодын байгууллагууд хоорондоо локаль сүлжээгээр холбогдсон болно. Түүнчлэн ЦТУХороо, БОЯ-ны харьяаны МТТ-д "Байгаль орчны мэдээллийн төв сан" байгуулсан. Эндээс газар, ус, ой, ургамал, ус , цаг уур, ан амьтан, нийгэм, эдийн засгийн талаарх холбогдох мэдээллийг авах ашиглах боломжтой. Мен зарим газар нутаг, байгалийн неецийн төрөл, төлөв байдлын талаар ГМС-ийг байгуулж байна. Мэдээллийн санг өргөжүүлэх зорилгоор жил бүр улсын сангаас дэмжлэг авч тодорхой зорилгыг шийдвэрлэдэг.

ЦТУХороо нь цөлжилттэй тэмцэх, газрын менежмент хийх үйл ажиллагаатай холбоо бүхий үндэсний байгууллагын талаархи "[http://ag.arizona.edu\(OALS\)CSTCCD](http://ag.arizona.edu(OALS)CSTCCD)" веб хуудас нээж, мэдээллийн сантай болсон. Мен ЦТ Конвенцийн биелэлт, тайлан зэрэг удирдлагын хэмжээний сан байгуулаад байна. Байгалийн гамшигт үзэгдэл, түүний дотор цөлжилтийн эрсдэлийн үнэлгээг 1:250000 масштабын зургаар хийж, газарзүйн мэдээллийн систем бүрдүүлээд байна. Мен цөлжилтийн төлөв байдлын 1:5000000 масштабтай зураг зохиолоо. Үндэсний зохицуулах байгууллагаас дотоод мэдээллийн солилцоог төрийн болон төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээний байгууллагын хооронд зохион байгуулж, гадаад мэдээллийг Цөлжилттэй Тэмцэх Конвенцийн Нарийн бичгийн дарга нарын газар, ЮНСО,ЮНЕП зэрэг байгууллагатай солилцож байна.

4.2. Үндэсний зохицуулах байгууллагаас цөлжилтийн байдалд байнга хяналт тавих бүтэц зохион байгуулалт

Цэлжилтэд хяналт тавих байнгын үйл ажиллагааг:

- Ус цаг уур, орчны шинжилгээний өртөө, харуулын служээ
- Газар зохион байгуулах албаны газрын менежментийн мэргэжилтнүүд
- Шинжлэх ухааны академийн судлаачид
- БОЯ-ны Мэдээлэл, тооцооллын төвийн танадан судалгааны хэсэг

зэргийг ашиглан хэрэгжүүлж байна.

Засгийн газраас газрын харилцаа, менежмент, кадастрын зураглал, хяналт тавих зэргэг эрх бүхий байгууллагын хүчийг нэгтгэх, шинэ механизм бий болгох талаар зарим нэг үнэлгээ, дүгнэлт хийсэн боловч хэрэгжүүлж амжаагүй байна.

Монгол оронд цэлжилтэнд хүчтэй нэрвэгдсэн газрын нэг болох Говь-Алтай аймгийн Хөхморьт суманд 1998 оны 6-р сард Говь-Алтай, Ховд, Завхан аймгийн 10 гаруй сумын иргэдийн хурлын төлөөлөгчид, засаг дарга, түүний тамгын газар болон иргэдийн төлөөллийг оролцуулан семинар сургалтыг явуулсан нь цэлжилтийн шалтгаан үр дагаврыг олон түмэнд таниулан, түүнээс урьдчилан сэргийлэх тэмцэх аргыг сурталчлах, ус бэлчээрийг зохистой ашиглах, хөрсийг элэгдэл, зэвдрэлээс хамгаалах арга ажиллагаанд иргэдийн идэвх оролцоог нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой боллоо. Түүнчлэн ган, цэлжилтэй тэмцэх олон улсын өдрийг жил бүр тэмдэглэж 6-р сарын 17-нд телевиз, хэвлэл мэдээллийн хэрэгслээр НҮБ-ын конвенц, үндэсний хетелбэрийн ач холбогдол, ган цэлжилтийн хор уршиг, үр дагаврыг арилгах арга, ажиллагаанд хүүхэд, эмэгтэйчүүд, залуучуудыг сургах, дадлагажуулах, нийгмийн давхаргыг өргөн хамруулах талаар сурталчлах зэргээр олон талт арга хэмжээг байнга явуулдаг сайhan уламжлал тогтов.

Газрын доройтол, талхлагдалтай тэмцэх асуудлыг үндэсний бодлогын түвшинд авч үзэж түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээг орон нутгийн түвшинд гүйцэтгэж байна. Газрын доройтолд тавих хяналт, арга ажиллагаандаа дүн шинжилгээ хийж, газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулахаар шийдсэн нь одоогийн механизмыг улам боловсронгуй болгож бэхжүүлэх зохион байгуулалтыг шинэчлэх ажлын үндэслэл болов.

Цэлжилт болон газрын доройтолд хяналт тавих үйл ажиллагааг дүгнэн үзсэний үндсэн дээр 1997 онд "Газар зохион байгуулалтын

албыг" шинээр байгуулж, түүний салбаруудыг орон нутагт байгуулсан юм. Үүний үр дүнд газар зохион байгуулалтыг 21 аймагт шинэчлэн хийж, жил бүр газрын сангийн тайлан гаргаж, Газрын хуулийн хүрээнд газрыг иргэдээз зэмшүүлэх, ашиглуулах, гэрчилгээжүүлэх ажлыг хийв. Одоогоор нийслэл Улаанбаатар хот, 21 аймгийн 218 мянган иргэн, аж ахуйн нэгж нийтдээ 1.4 сая га газрыг зэмших эрхийн гэрчилгээ аваад байна.

Цаашдаа газар тариалан бүхий газар нутгуудад газрын кадастр хийх бэлтгэлийг хангаж байна.

4.3. Үйл ажиллагааны үндэсний хөтөлбөр нь үндэсний эдийн засаг, нийгмийн хөгжлийн болон байгаль орчныг хамгаалах, төлөвлөгөөний нэг хэсэг мөн.

4.3.1. Үндэсний хөтөлбөрийг байгаль орчны болон бусад стратеги төлөвлөлтийн тогтолцоотой уялдуулах нь. Целжилттэй тэмцэх үйл ажиллагааны үндэсний хөтөлбөр(ЦТҮХ)-ийг 1996 онд Засгийн газраас баталж, түүнийг бусад хөтөлбөрүүдийг уялдуулав. Үүнд:

- Монгол улсын Үндэсний хөгжлийн үзэл баримтлал (1996)
- Монгол улсын ХХI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр(1998)
- Тереес экологийн талаар баримтлах бодлого(1997)
- Байгаль орчны үйл ажиллагааны хөтөлбөр(1996)
- Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр(1998)
- Бүх нийтэд экологийн боловсрол олгох тухай үндэсний хөтөлбөр(1997)
- Ойн тухай үндэсний хөтөлбөр(1998)
- Байгалийн гамшигийн аюулыг бууруулах үндэсний хөтөлбөр(1998)
- Монгол орны биологийн төрөл зүйлийг хамгаалах үйл ажиллагааны үндэсний хөтөлбөр (1996)
- Усны үндэсний хөтөлбөр (1999)
- Хогхаягдлыг бууруулах тухай хөтөлбөр (1999)

зэргүүдтэй уялдуулан зохицуулалт хийсэн болно. 1998 онд бүх хөтөлбөрүүдэд дүн шинжилгээ хийж, үнэлгээ дүгнэлт өгөх талаар үндэсний хэмжээнд семинар зохион байгуулж зохих зөвлөмж гарган хэрэгжүүлж байна.

4.3.2 Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр үндэсний хөгжлийн хандлагатай уялдуулах нь. Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг Зүйл шатанд төрийн төв болон орон нутгийн төр захиргааны байгууллагуудын ажил төрлийн уялдаа холбоог бэхжүүлэх, эрх мэдлийг нэмэгдүүлэх, цөлжилтэнд хүчтэй нэрвэгдсэн зарим газруудад цөлжилтийг сааруулах арга хэмжээг хэрэгжүүлэх зарим ажлыг эхлээд байна. Мен цөлжилт, газрын доройтлыг бууруулахад чиглэсэн нэн тэргүүнд шаардлагатай газрын харилцааны эрх зүйн орчинг бурдүүлэв. **Дараагийн үе шатанд** цөлжилтийн явцад тавих мониторингийн системийг бүрдүүлэх, цаашид цөлжилтэнд нэрвэгдэх боломжтой газруудыг тодруулах, газрын доройтлын эрч хүчийг сааруулан зогсоох технологийг боловсруулна. **Харин сүүлчийн үе шатанд** цөлжилттэй тэмцэх хөтөлбөр нийт үндэсний хэмжээний чадавх болон бахжинэ. Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хамгийн чухал зорилтын нэг бол **цөлжилттэй тэмцэх үндэсний чадавхийг бүрдүүлэх** явдал билээ. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд цөлжилтэнд үлээмж их нэрвэгдсэн Дорноговь аймгийн Замын-Үүд суманд НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгээр "Газрын менежментийг боловсронгуй болгох, цөлжилттэй тэмцэх" жижиг төслийг хэрэгжүүлсэн нь энэ нутгийн цөлжилтийн шалтгаан үр дагаврыг тогтоох, газар ашиглалттай холбоотой зөрчил бэрхшээлийг судлан, газар, ус, бэлчээрийн менежментийг боловсронгуй болгох, элсний нүүдлийг зогсооход биологийн арга хэрэглэх, мод сөөг тарих, ургамалжуулах ажилд оршин суугчдыг сургах талаар орон нутгийн чадавхийг бий болгоход ихээхэн үр дүн өгсөн юм. Цөлжилттэй тэмцэх үйл ажиллагааг нийгэм, эдийн засгийн бүхий л давхарыг аль болох иж бүрэн хамруулж, давхардал болон хүн хүчний тарамдлыг арилгах үүднээс үндэсний хөтөлбөрийг байгаль хамгааллын бусад салбарын ялангуяа дэд бүтцийн стратеги төлөвлөлттэй уялдуулж өгснөөр хандивлагч орнуудын болон олон улсын байгууллагын дэмжлэг туслалцааг чиглүүлэхэд хялбар дехем боллоо. Газрын шинэтгэлийн бодлогыг гүнзгийрүүлэх зорилгоор газрын нэгдсэн ангиллын шинэчилсэн бүртгэлийг хийж, газрын шинэтгэлийн талаарх зохих хуулиудыг хууль тогтоох дээд байгууллагаас батлан гаргасан нь байгалийн нөөцийг ард иргэд зохистой ашиглан цөлжилт, хуурайшилтаас сэргийлэхэд ихээхэн тулхэц болж байна. Байгаль орчны салбарт тусгай хамгаалалттай газар нутаг, ус, бэлчээр, байгалийн гамшигийн серег үр дагаврыг арилгах зэрэг үндэсний 10-аад төрөлжсөн хөтөлбөрүүдийг УИХ, Засгийн газар батлан хэрэгжүүлснээс гадна цөлжилтийг сааруулах ажлыг эрчимжүүлэх, доройтсон газрыг сэргээх, усны нөөцийг тогтоож ашиглалтыг сайжруулах, хөрсний элэгдэл эвдрэлийг бууруулах, газар бэлчээрийн менежментийг боловсронгуй болгоход чиглэгдсэн 20 шахам төсөлт ажлыг гэрээгээр гүйцэтгэхэд төсвееес хөрөнгө зарцуулж байна. Үндэсний хэмжээнд эх

орныхоо байгаль, экологийн даацаанд нийцсэн нийгэм-эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад териин бодлого чиглэж байна. Ийнхүү НҮБ-ын конвенцийн зарчмыг үндэсний болон орон нутгийн түвшний байгаль орчин нийгэм, эдийн засгийн бусад салбаруудын төлөвлөгөө хөтөлбөрүүдтэй уялдуулан нийцүүлснээр цэлжилттэй тэмцэх хөтөлбөр нь улс орны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд стратеги тогтолцоо болж бүрэн хэмжээгээр тусгалаа оллоо.

4.3.3. Цэлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг дэд бүсийн үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулах нь. Азийн орнууд Цэлжилттэй тэмцэх конвенцийг хэрэгжүүлэх зорилгоор хэд хэдэн удаа семинар, хурал зохион байгуулж, Азийн бүсийн **сэдэвчилсэн хөтөлбөрийн сүлжээг /СХС/** байгуулаад байна. Монгол улс эдгээр сэдэвчилсэн хөтөлбөрийн сүлжээг бүрэн дэмжиж тэдгээрийн 6 сэдэвт хамтран оролцохоо илэрхийллээ. Түүнчлэн тус сэдэвчилсэн хөтөлбөрийн сүлжээний 5 дахь хэсэг болох "Гангийн нелеөг бууруулах, цэлжилттэй тэмцэх чадавхийг бэхжүүлэх" сэдэвийг Монгол улс хариуцан гүйцэтгэхээр сонгогдоод байна. Энэ талаар одоогоор манай улс төслийн санал боловсруулж байгаа бөгөөд холбогдох мэргэжилтнүүдээ БНХАУ, Энэтхэг, Израиль зэрэг орнуудад сургаж бэлтгэж байна.

4.3.4. Засгийн газрын зөвшөөрөл. Монгол улсын Засгийн газар 1996 онд Цэлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг (Засгийн газрын тогтоол №169) баталж албан ёсны бусад хөтөлбөр, стратеги, төлөвлөгөө, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусган үе шаттай хэрэгжкуулж байна. Мен жил бүр Засгийн газрын төсөв, төлөвлөгөөнд Цэлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хэсэг болох ойжуулалт хийх, ойн хенеөнт шавьжтай тэмцэх, тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг сайжруулах, газар зохион байгуулалтыг бэхжүүлэх, бэлчээр нутгийг усжуулах, зарим газрыг нөхөн сэргээх зэргээр байнга хөрөнгө, санхүүгийн нөөцийг төлөвлөн хэрэгжүүлж байна.

4.4. Эрх зүйн уялдаа, холбоо бүхий зохицуулах тогтолцоо

4.4.1. Байгаль орчны хууль тогтоомжинд дун шинжилгээ хийх нь. Монгол улсад 1994 он хүртэл байгаль орчны б хууль үйлчилж байлаа. Эдгээр хуулиудад дун шинжилгээ, үнэлгээ хийж шинэ нехцэлд бүх хуулийг шинчилэн боловсруулснаар Монгол Улсын Их Хурал (1994-1999 онд) 20 гаруй хууль батлан гаргаад байна. Эдгээр хууль, тогтоомжид байгаль орчныг хамгаалах, газрын доройтол, цэлжилтөөс сэргийлэх, тэмцэхэд орон нутгийн хүн амын үүргийг өндөржүүлэх, тэдний оролцоог нэмэгдүүлэх, иргэдэд мэдээлэл хүргэх,

сурталчилгааг өргөжүүлэх, газар нутгаа урт хугацаанд тогтвортой бөгөөд зохистой ашиглахад чиглэсэн олон заалтууд орж хэрэгжиж байна.

Газрын дорийтол, талхлагдлыг бууруулах цэлжилттэй тэмцэх ўйл ажиллагаанд орон нутгийн удирдлага, олон нийтийн үүсгэл санаачлагын байгууллага хувийн сектор, шинжлэх ухаан, эмэгтэйчүүд, залуучууд зэрэг бүх давхаргын үүрэг хариуцлагыг хангах, газар ззэмших тогтвортой тогтолцоог бий болгох нехцелийг бүрдүүлэхийн тулд өмнө мөрдэж байсан байгаль орчны болон бусад хууль тогтоомжинд дүн шинжилгээ хийж хоорондоо уялдаа холбоо бүхий ажиллах чадвартай эрхзүйн шинэ орчинг бүрдүүллээ. Төрөөс байгаль орчиныг хамгаалах цэлжилттэй тэмцэх бодлогын дагуу эрхзүй, эдийн засаг, зохион байгуулалтын үндсийг боловсронгуй болгон төлөвшүүлэх зорилгоор "Төрөөс экологийн талаар баримтлах бодлого" болон байгаль орчны дорийтлыг хязгаарлан зогсоох, байгалийн нөөцийн ашиглалт хамгаалалтын харьцааг тэнцвэржүүлэх, дахин сэргээгдэх баялагийн нехен үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, орчны эрүүл ахуйн нехцелийг хангахтай холбогдсон харилцааг зохицуулах дээрхи 20 гаруй хууль, эрх зүйн 200 гаруй актыг батлан гаргасан нь олон түмний ялангуяа орон нутгийн хүн амын өргөн оролцоог дэмжих, хөгжүүлэхэд чиглэгдсэн цоо шинэ орчин нехцел бий болов.

4.4.2. Газрын шинэтгэл. Газрын шинэтгэлийн бодлогыг хэрэгжүүлэх, төвлөрөлийг сааруулах, орон нутгийн биээ даасан байдлыг хангах зорилгоор эрх зүй, зохион байгуулалтын веерчлэлт хийлээ.

Монгол улсын Газрын хуулийг 1994 онд(УИХ-ын хууль.1994.) батлан гаргаж уг хуульд дараах гол асуудлыг шийдвэв. Үнднд:

- Газрыг Монгол улсын иргэдэд 100 жил хүртэл эзэмшүүлэх
- Газар ззэмшүүлэх, ашиглах эрхийг орон нутаг шийдэх (төвлөрлийг сааруулах)
- Газар зохион байгуулалтыг сайжруулах

Монгол Улсын иргэдэд газар өмчлүүлэх талаар судалгаа, дүгнэлт хийж байна. Түүнчлэн байгалийн нөөцийг ард иргэд ашиглуулах, ззэмшүүлэх, түүний менежментийг сайжруулах эрх зүйн үндсийг тавиад, одоо эдийн засгийн үндсийг бүрдүүлэх ажил эхлээд байна.

Ард иргэдийн амьдралын эх үүсвэр болсон газар нутгаа түшин амьдрах, ззэмших эрхийг нэмэгдүүлэх зорилгоор газрын шинэтгэлийн ўйл ажиллагааны хүрээнд байгалийн нөөцийн менежментийг боловсронгуй болгоход чиглэгдсэн Ойн тухай, Усны тухай, Газрын тухай, Ургамлын тухай хуулиудыг шинэчлэн УИХ-аар батлан гаргав. Эдгэр хуулийн бодлого түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдсон Засгийн

газрын тогтоол, дүрэм журмын агуулгыг нийт ард иргэд ялангуяа орон нутгийн хүн амд сурталчлан ойлгуулах, мэдээллээр хангахад чиглэйдсэн олон терлийн ажлыг зохион байгуулж байна. Тухайлбал Монгол улсын Засгийн газрын баталсан "Албан бус боловсролын үндэсний хөтөлбөр" ЮНЕСКО-ийн дэмжлэгээр хэрэгжүүлж байгаа "Зайн сургалт, сурч амьдартья" тесел зэрэг нь сургуулийн гадна байгаа олон мяняган хүүхэд, залуучууд, насанд хүрэгчдэд экологийн боловсрол олон, НҮБ-ийн Цэлжилттэй тэмцэх конвенц, цэлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн зорилго, чиглэлийн талаарх мэдээ, мэдээллийг түгзэсэн үндэсний хэмжээнд явуулж байгаа томоохон үйл ажиллагаа болж байна.

Орон нутгийн хүн ам байгалийн нөөц баялаг, газар, ус, ой, бэлчээр, тариалангийн газраа хэрхэн зохистой ашиглах талаар байнга радио, телевиз, хэвлэл мэдээллээр сурталчилгаа хийж, зөвлөмж өгч байна. Мөн дээрхи чиглэлээр тухайлсан судалгааны хэд хэдэн теслийг хэрэгжүүлэв. Тухайлбал, ДАНИДА-гийн туламжаар.govийн бүсийн Дорноговь, хангайн бүсийн Архангай аймагт "Байгалийн нөөцийн /газар, ус г.м/ менежмент, телеввлэлтийн систем" теслийг 1996-1997 онд хэрэгжүүлж, холбогдох бүхий л арга хэмжээ, бодлого зохицуулалтанд орон нутгийн удирдлага, малчдыг оролцуулах, сургалт семинар хийх, ярилцлага хийх, газар төлөвлөлт, ашиглалт, газар хуваарилалтын загвар гаргах арга хэмжээ авсан.

НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөртэй хамтран "Хамтын эзэмшлийн ойн газар бий" болгох теслийг 1997-1998 онд хэрэгжүүлж, одоогоор Сэлэнгэ, Хэнтий, Архангай аймагт орон нутгийн иргэдийн оролцоотой 8 хамтлаг бий болоод байна.

Улсын түгсгай хамгаалалттай газар нутаг, түүний орчны бусэд ард иргэд амьдрах, аж төрөх нехцелийг хангах, тэдний оролцоог нэмэгдүүлж, газраа хамгаалахад анхаарсны үр дүнд уг орчны бүсэд 20000 гаруй хүн 600000 гаруй мал сүрэг байнга идээшилж байна.

Ийнхүү нийт ард иргэд ялангуяа орон нутгийн удирдлагын түвшинд цэлжилт, газрын талхлагдалтай тэмцэх талаар шийдвэр гаргахад оролцох чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн олон арга хэмжээнүүдийг дэс дараатай авч хэрэгжүүлж байна.

5.ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ БОЛОВСРУУЛЖ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦОО

5.1 Үндэсний хэмжээний асуудлын зэрэглэлийг тогтооход оролцогч талуудын үр нөлөөг дээшлүүлэх нь

Засгийн газраас батлан гаргасан гол гол үндэсний хэмжээний бодлогын баримт бичиг болох "Монгол улсын ХХI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр (MX-21)", "Цэлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг" боловсруулж хэрэгжүүлэхэд Улсын их хурал, Засгийн Газрын байгууллага, төрийн бус байгууллагууд, хувийн хэвшил, их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагууд, орон нутгийн төлөөлөгчдийг үндэсний хэмжээний болон бус нутгийн уулзалт, шинжлэх ухаан-үйлдвэрлэлийн хурал, зөвлөгөөнүүдэд байнга урьж оролцуулан, тэдний санал бодлыг тусгаж байна.

Байгаль орчны яаманд 1997-1998 онд хэрэгжсэн НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөрийн "Байгаль орчны мэдээлэл, сурталчилгааны теслээр" Байгаль орчныг хамгаалах, цэлжилттэй тэмцэх гол стратеги болох "Байгаль орчны мэдээлэл сурталчилгааны (БОМС)" хөтөлбөрийг боловсруулж, 1999 онд Байгаль орчны сайдын 39 тоот тушаалаар батлан гаргав. Энэхүү БОМС-ний хөтөлбөрийн хүрээнд цэлжилттэй тэмцэх, байгаль орчныг хамгаалах талаар эмзгэйчүүд, залуучууд, хүүхэд, байгаль орчны зэрэг олон ТББ-ыг оролцуулан маш өргөн хүрээтэй мэдээлэл сурталчилгааны ажлыг хэрэгжүүлэв.

Цэлжилттэй тэмцэх үндэсний хорооноос төв, орон нутгийн төрийн байгууллагууд, төрийн бус байгууллагын ажилтнууд, орон нутгийн төлөөлөгчдийг цэлжилттэй тэмцэх тухай конвенцийн хэрэгжилтийн талаар үнэн зөв мэдээллээр хангаж байгаа нь тэднийг шийдвэр гаргахад чухал арга хэмжээ болж байна.

MAP-21 болон Монгол улсын цэлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрт олон нийтэд мэдээлэл хүргэх, сурталчилгаа явуулах гол стратегийг үндэсний болон орон нутгийн хэмжээнд тодорхойлсон. Энэ стратеги нь өнөө үед хэрэгжиж эхлээд байгаа болно.

Үндэсний хэмжээний стратегийн зэрэглэлийг тодорхойлоход төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн оролцогчтой хэд хэдэн уулзалт, семинар зохион байгуулж, хөтөлбөрт тусган оруулсан болно.

Негee талаар хөтөлбөрийн зэрэглэлийн дагуу төсөл хэрэгжүүлэх, үйл ажиллагаа явуулах, мэдээлэл хүргэх, солилцох зэрэгт үндэсний хэмжээний и-мэйл, холбоо мэдээллийн сүлжээг өргөн хэмжээтэй ашиглаж байна.

Цэлжилт, газрын доройтолттой тэмцэх болон БОМС-г явуулахад дахраах материалыг ашиглаж байна. Үүнд:

- Ном, товхимол, эмхэтгэл
- Товч танилцуулга, эвхмэл хуудас

- Зурагт хуудас
- Зурагт танилцуулга
- Ханын самбар, зурагт сонин
- Сонин, сэтгүүл
- Видео бичлэг, видео кино
- Слайд, дуут танилцуулга
- Календарь
- Лавлах материал
- Бусад

Эдгээрийг ашиглан олон нийтэд хүргэхэд цуглаан хийх, аялал экскурс зохиох, газар дээр нь танилцах уулзалт хийх, харилцан ярилцлага хийх, тэмцээн зохиох, асуулт хариултын уралдаан хийх, бодит ажил хийх арга хэмжээг явуулах зэрэг өргөн хэлбэрийг ашиглаж байна.

Энэхүү БОМС-ний арга хэмжээ нь эмэгтэйчүүд, залуучууд, хүүхэд, малчид, тариаланчид, гэрийн эзэгтэй зэрэг олон нийтийн давхартыг хамран өргөн хэмжээтэй өрнөж байлаа. Олон түмэн ч оролцох сонирхолтой байдаг.

5.1.1 Уулзалт, зөвлөлгөөн арга хэмжээнд олон нийтийн төлөөллийг бий болгох арга зам Целжилт, байгалийн гамшигийн сурталчилгааны ажлыг явуулахад териийн байгууллага болон "Хөгжил орчин төв", "Очирбат сан", "Монголын байгаль орчныг хамгаалах холбоо", "Монголын эмэгтэйчүүдийн холбоо" зэрэг териийн бус байгууллагууд, түүнчлэн шинжлэх ухааны байгууллагуудын оролцотойгоор 1997-2000 онд Улаанбаатар хотод 8 удаа байгаль орчин, цөлжилтийн асуудлаар уулзалт, хуралдаан, зөвлөлгөөнийг зохион байгуулж 500-аад хүнийг хамруупан 150 гаруй судалгаа, шинжилгээ, сурталчилгааны өгүүллийг багтаасан 10-аад ном, товхимол, тэмдэглэлийн багц зэргийг 2000-аад хувь хэвлэж олны хүртээл болгосон байна.

Энэ ажлыг "Очирбат сан" ТББ болон байгаль орчны үнэлгээ, зөвлөлгөөнгөө ажлыг эрхэлсэн хувийн хэвшлийн байгууллага "ЭНКО" ХХК, "ЭКОС" ХХК, "ЭКО-ТРЕЙД" ХХК, "ЭКОЛОГИ" ХХК, "ЭКО-МОН" ХХК-иуд удаа дараа зохион байгуулж санхүүгийн дэмжлэг үзүүлсэн болно.

Целжилт, байгалийн гамшиг, экосистемийн өөрчлөлтийн асуудлаар уулзалт, зөвлөлгөөн, сургалт семинарыг целжилтийн асуудал хурцаар тавигдаж буй Говийн бус (Сайншанд, Замын-Үүд, Даланзадгад хот, Говь-Алтай аймгийн Хөх Морьт сум г.м) Баруун бүсийн Ховд, Улаангом хотод целжилт, экосистемийн төлөө байдлын асуудлаар Монгол-ОХУ-ын хамтарсан эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулж, орон нутгийн териийн байгууллагуудын ажилтнуудыг оролцуулсан. Эдгээрт хэдэн мянган хүн хамрагдсаны 15 хувь нь

эмэгтэйчүүд байгаа юм.

Терийн бус байгууллага, эрдэм шинжилгээний болон орон нутгийн эмэгтэйчүүдийн байгууллагын оролцоотойгоор Говь-Алтай аймгийн Хөхморьт сум, Дорнговь аймгийн Замын-Үүдэд цөлжилттэй тэмцэж байгааг харуулсан видео кино хийж, Монголын цөлжилттэй тэмцэх ажил, конвенцийн сурталчилгааны талаарх товхимолыг 2000 хувь хэвлэн нийтийн хүртээл болголоо.

Мен Цөлжилттэй тэмцэх конвенцийн НБДГ-ын тусламж дэмжлэгтэйгээр Дундговь аймагт эмэгтэйчүүдийн байгууллага, тэдний оролцоотойгоор цөлжилттэй тэмцэх, говийн бут сеегийг хамгаалах, тэдгээрийг түлшинд хэрэглэхийг багасгах, түвш орлуулахад нунтаг нүүрс ашиглан брикетэн түвш бэлтгэх, говийн бэлчээр нутагт ус татах насос суурилуулах, говьд мод бут суулгах тесел хэрэгжүүлсэн нь амжилттай боллоо.

Цөлжилтийн талаар судалгаа явуулдаг байгууллага, эрдэмтэд судлаачдын талаарх мэдээллийг нэгтгэн интернетийн сүлжээнд оруулж, „<http://ag.arizona.edu/OALS> CSTCCD” веб хуудсыг нээж, мэдээллийн сан байгуулж гадаад, дотоодын сонирхогчдын хүртээл болгох ажлыг зохион байгуулж байна. Ийнхүү хурал зөвлөлгөен, семинар сурталчилгааны ажлыг өргөн хэмжээтэй зохион байгуулж, цөлжилтийн эсрэг тэмцэхэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлж байгаа нь зохих үр ашгаа өгч байна.

Цөлжилттэй тэмцэх бодлого боловсруулах, мэдээлэл сурталчилгаа хийх, мэдээлэл солилцох зэрэг арга хэмжээнүүдийн 30-40 хувьд нь эмэгтэйчүүд, мөн 20-25 хувьд нь залуучууд оролцож байна.

Монгол улсын хүн амын 58.5 хувь нь 25 хүрэх насны залуучууд, газрын үржил шимийг шууд ашиглан хүртэж байгаа хөдөөгийн хүн амын 55 орчим хувь нь эмэгтэйчүүд байдаг бөгөөд ялангуяа говь нутагт эмэгтэйчүүд олноор амьдардаг учир эдгээрт цөлжилттэй тэмцэх, газар нутгаа зохицой ашиглах хамгаалах зорилгоор хэвлэл мэдээлэл, зайны сургалтаар мэдээлэл хүргэж байна.

5.1.2 Үндэсний хэмжээний арга хэмжээний зэрэглэлийг тогтооход оролцогч Талуудын төлөөлөл Байгаль орчныг хамгаалах болон цөлжилттэй тэмцэх, сэргийлэх, мэдээлэл сурталчилгааны ажлыг хенгев-чилхед байгаль орчны териин бус байгууллагууд болох “Хөгжил орчин төв” ТББ, МБОХХ; эмэгтэйчүүдийн байгууллага болох Монголын эмэгтэйчүүдийн холбоо, Социалдемократ эмэгтэйчүүдийн холбоо, Монголын залуучуудын холбоо зэрэг териин бус нэлээд олон байгууллага, байгаль орчны зөвлөлгөө, үнэлгээний компаний зөвлөхүүд оролцож, туслалцаа үзүүлдэг.

Тэдгээр байгууллагыг оролцуулан БОМС хийлгэх үүрэг зорилгод сургахын тулд БОЯ, НҮБ-ын ХХ-ийн “БОМС” төслийн хүрээнд

1997-1998 онд 10 гаруй удаа цуврал сургалт, семинар, аргачлалын сургалт зохион байгуулсан нь үр дүнгээ егч байна.

Мен эдээр оролцогч талууд болон ТББ-тай Европын холбооны ТАСИС төслийн хүрээнд байнга зөвлөлдөх, тэдгээрийн чадавхийг дээшлүүлэх сургалт, уулзалт, ярилцлага явуулах, байгаль орчны ТББ-ын үйл ажиллагааг зохицуулах, зохион байгуулах, чадавхийг дээшлүүлэх зөвлөл байгуулан улирал тутам уулзаж, хамтран ажиллах, мэдээлэл солилцох арга хэмжээг авч байна.

Сурталчилгааны ажлыг явуулах, зөвлөлдөхөд дараах санхүүгийн механизмийг ашиглаж байна.

- Үндэсний хэмжээний уулзалт, мэдээлэл солилцох ажлыг төрийн өмчийн байгууллага болон олон улсын байгууллагын дэмжлэгтэй зохион байгуулах
- Үндэсний болон орон нутгийн уулзалтыг төрийн бус байгууллага, хувийн өмчийн байгууллагын санхүүгийн дэмжлэгтэй зохион байгуулах
- Олон нийтийн үүсгэл санаачлагын байгууллагаас зохион байгуулах зэрэг төрлөөр явагдах байна.

Энэ үүрэг зорилгод зориулсан сургалтыг 1997-1999 онд 10 гаруй удаа зохион явуулж 4000 гаруй хүний хамруулсан.

Үндэсний хэмжээний зөвлөлдөх, мэдээлэл солилцох ажлыг орон нутагт бүсчилэн зохион байгуулж байгаа нь хөдөө нутгийн олон нийтийн төлөөллийг өргөсгөхөд үлэмж тус дэхөм боллоо.

5.1.3 Мэдээлэл, боловсрол, харилцааны төрөл

Мэдээллийг солилцох, тараах дараах систем тогтоод байна. Үүнд:
Олон нийтийн мэдээллийн хэрэгслэл

- радио, телевиз
- Сонин, тогтмол сэтгүүл
- Интернет, веб хуудас, электрон шуудан
- Зурагт хуудас
- Ном, товхимол
- CD
- Видео бичлэг, хуурцаг
- Албан бус боловсролын сургалт
- Явуулын сурталчилгаа
- Бусад

Мэдээллийг солилцох, тараах дараах арга хэмжээг авав. Үүнд:

- Цэлжилтийн судалгаа, сурталчилгааны материал орсон 10-аад төрлийн ном, товхимол, зурагт хуудас гаргасан
- Үндэсний радио, телевизээр цэлжилтэес сэргийлэх, тэмцэх сурталчилгааг жилд 6-8 удаа зохион байгуулж байна.

- Цөлжилтийн талаар сүүлийн 3 жилд 4 видео кино хийж сурталчилгаанд ашиглагв.
- Цөлжилтийн талаар судалгаа явуулдаг 20 гаруй байгууллага 100-д хүмүүсийн тухай мэдээллийг интернетийн сүлжээнд оруулж веб хуудас байгуулан мэдээлэл солилцож байна.
- Цөлжилтийн сэдвээр дагнасан сонины 3 дугаар гарган олон нийтэд түгээв.
- Явуулын аялал, сурталчилгааны ажлыг хөдөө орон нутагт 3 удаа зохион байгуулав.

Одоогийн байдлаар мэдээллээр хангах, мэдээллийн сүлжээнээс мэдээлэл олж авах үйл ажиллагаанд янз бурийн оролцогч талуудыг оруулах асуудал эхэлж байгаа боловч зарим нэг техник хэрэгслэл, тоног төхөөрөмжийн боломж тедий л сайн бүрдэж чадаагүй байгааг тэмдэглэх нь зүйтэй юм. Негеө талаар орон нутагт, ялангуяа сум, багт, өрх айлд мэдээлэл хүргэхэд бэрхшээлтэй хэвээр л байсаар байна.

5.1.4. Хамтран ажиллах, харилцан ойлгох зэрэглэл

- **Орон нутгийн асуудлыг үндэсний түвшинд**
- **Үндэсний хэмжээний зөвлөлдөөний үр дүнг орон нутгийн түвшинд**

1995, 1997, 1998, 1999 болон 2000 оны эхээр цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг боловсруулах, нарийвчлах, үнэлгээ дүгнэлт өгөх болон газар, ус, ойн хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх асуудлаар цуврал сургалт-семинар зохион байгуулж үндэсний хэмжээний асуудлыг хэлэлцэхэд нийслэл хот, 21 аймгийн төлөөлөгчдийг оролцуулсан арга хэмжээг зохион байгуулав.

Жил бүр газар зохион байгуулалт, газрыг зохистой ашиглах талаар семинар хийж байна. Семинарын явцад УИХ-аар (парламентаар) хэлэлцэх газар ашиглалт, цөлжилттэй тэмцэхтэй холбоотой хууль, тогтоолийн теслийг хэлэлцэж оролцогчдын санал зөвлөмжийг тусгадаг. Орон нутгийн түвшний асуудлыг ийнхүү семинар, уулзалтын үеэр тэдний төлөөллийг оролцуулж тодорхойлон гаргаж, үндэсний хэмжээний бодлого зохицуулалт хийх, хууль эрх зүйн үндсийг тогтооход тусгадаг нь хэвшмэл арга, механизм боллоо.

Харин үндэсний хэмжээний асуудлыг орон нутгийн түвшинд ойлголцох, механизм нь одоогийн байдлаар эхэллийн шатандаа байгаа. Гэхдээ 5.3.1-д дурьдсан мэдээлэл хүргэх тогтолцоог ашигладаг боловч

сум, баг, айл өрхийн түвшинд хургэхэд бэрхшээл учирсаар л байна. Нийгмийн болон байгууллагуудын янз бүрийн бүлгүүдийн төлөөвлөгчдийн зөвлөлдөх үйл ажиллагааг цаашид сайжруулах, мэдээлэл хургэх хэрэгсэл, сүлжээг улам өргөжүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

**6. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ
БОЛОВСРУУЛЖ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗӨВЛӨЛДӨӨНИЙ ҮЙЛ
ЯВЦАА ХӨГЖИНГҮЙ ОРОН - ТАЛУУД БОЛОН СОНИРХСОН
БУСАД БАЙГУУЛЛАГУУДТАЙ БАЙГУУЛСАН ТҮНШЛЭЛИЙН
ГЭРЭЭ**

**6.1. Олон улсын түншүүдийг үйл ажиллагаанд оролцуулах талаар
Засгийн газраас авсан арга хэмжээ:**

6.1.1. Засгийн газраас авсан арга хэмжээ. Монгол улсын Засгийн газраас Целжилттэй тэмцэх Конвенцийг хэрэгжүүлэх явцад олон улсын байгууллага болон хандивлагч орнуудын тусlamж, дэмжлэгийг чиглүүлэх бодлого стратегийг чухалчлан үзэж энэ чиглэлээр өргөн хүрээнд хамтын ажиллагааг хөгжүүлж байна.

Монгол улсын Байгаль орчны яам жил бүр "Байгаль орчны төлөв байдлын тайланг" судалгааны үндсэн дээр гаргадаг бөгөөд 1996 оны төлөв байдлын тайланд үндэслэн ган целжилт, газрын доройтлын асуудал нь Монгол орны байгаль орчны нэн тэргүүлэх ач холбогдолтой болохыг тогтоож, целжилттэй тэмцэх ажлыг дотоод, гадаад түвшинд улам эрчимжүүлэх, олон улсын хамтын нийгэмлэгийн анхаарлыг энэ асуудалд хандуулах талаар чухал алхамуудыг хийсэн билээ.

НҮБ-ын Целжилттэй тэмцэх конвенцийг гаргах санаачлагыг Монгол улс анхнаасаа дэмжин, түүнийг боловсруулах, бэлтгэх бүх шатны үйл ажиллагаанд идэвхитэй оролцож 1994 оны 10 дугаар сард Парис хотноо нэгдэн орж гарын үсэг зурсан бөгөөд 1996 оны 8 сард Монгол улсын хууль сахиулах дээд байгууллага болох Улсын их хурлаар (Парламент) батламжилсан болно.

Монгол оронд тулгараад байгаа байгаль орчны асуудлууд тухайлбал газрын доройтолын нэг хэлбэр болох бэлчээрийн талхдал, доройтол, ой усталт, элсний нүүлт, цэвэр усны неөцийн хомсдол зэргийг дан ганц ёөрийн орны дотоод санхүү, эдийн засаг, техникийн чадавхиар шийдэх боломжгүй учир асуудлыг олон улсын хамтын нийгэмлэгийн тусlamжтайгаар шийдвэрлэх зорилгоор Хандивлагчдын уулзалтуудыг жил бүр зарлан хуралдуулж, тусlamжаар санхүүжүүлэх тэслийн саналуудыг бэлтгэн хэлэлцүүлж байна.

1990 оноос хойш Хандивлагчдын 6 удаагийн уулзалтыг Монгол улс Япон улстай хамтран Токио хотноо зохион байгуулж байв. Хандивлагчдын 7 дугаар уулзалтыг Монгол улс Дэлхийн банктай хамтран анх удаа Улаанбаатар хотод 1999 оны 7 сард зохион байгуулсан бөгөөд үүнд 24 орон, 11 олон улсын байгууллага, 3 ТББ оролцсох нийт амалсан хөрөнгийн 15 хувийг байгаль орчин болон хувийн хэвшлийг хөгжүүлэхэд чиглүүлэхээр уулзалтын баримт бичигт тодрхойлсон болно.

Херш зэргэлдээх орнууд болох ОХУ, БНХАУ болон байгалийн

нэгэн бүс бүслүүрт орших Казахстан, Киргиз улстай Засгийн газрын түвшинд байгаль орчин, усны нөөц, хилийн усыг хамгаалах, ус цаг уур, орчны мониторингийн салбарт хамтран ажиллах талаар нийт 7 гэрээ хэлэлцээр, АНУ, Исламын БН Иран, БНСУ, БНХАУ, ОХУ, Унгар, ХБНГУ, Япон зэрэг орны Байгаль орчныг хамгаалах ижил төстэй үүрэг бүхий яамдтай байгаль орчныг хамгаалах чиглэлээр 8 гэрээ хэлэлцээр, санамж бичиг байгуулж, үйл ажиллагааг хоёр талаас идэвхитэйгээр явуулж байна.

Цэлжилттэй тэмцэх үндэсний семинарыг 1995 болон 1997 онд ЮНСО болон ЦТК-ийн НБДГ-тай хамтран зохион байгуулж, Монгол улсад суугаа өндөр хөгжилтэй орнуудын элчин сайдын яамд, олон улсын байгууллагуудын төлөөлөгчдийг оролцуулан цэлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг боловсруулах, түүний хэрэгжилтэнд үнэлгээ, дүгнэлт өгөх зэрэг тулгамсан олон асуудлыг хэлэлцэж, зөвлөмж боловсруулан гаргаж ажиллав.

Монгол улс нь олон улсын байгууллагууд болон өндөр хөгжилтэй орнуудын засгийн газруудаас ган, цэлжилттэй тэмцэх, газрын доройтлыг бууруулах талаар арга хэмжээг авч явуулах санхүү, техникийн дэмжлэг хүссэн төслийн 20 гаруй саналыг боловсруулж 1996-1999 онуудад илгээсэн бөгөөд Засгийн газрын энэхүү идэвхитэй ажиллагаа болон олон улсын хамтын нийгэмлэгийн тусламж дэмжлэгээр нийт дүнгээрээ 24.6 сая ам долларын 14 төслийг 1993-2000 онд үндэсний болон орон нутгийн түвшинд хэрэгжүүлсэн буюу хэрэгжүүлж байна.

Үүнд:

Байгалийн нөөцийг хамгаалах, газар нутгийг улсын тусгай хамгаалалтанд авах, түүний менежментийг сайжруулах чиглэлээр

1. ХБНГУ-ын 21 сая Д.М санхүүжилтээр Улсын тусгай хамгаалалттай 2 газрын менежментийг үлгэр жишээ болгох зорилготой "Байгаль хамгаалал ба орчны бүсийн хөгжил" тесел, 1995-2006
2. ДДБОС/НУБХХ-ийн дэмжлэгээр "Дорнод Монголын тал хээрийн экосистем, биологийн төрөл зүйлийг хэмгаалах, газрын менежментийн оновчтой бодлогыг орон нутгийн хөгжлийн хөтөлбөрүүдтэй уялдуулах зорилго бүхий "Дорнод Монголын биологийн төрөл зүйлийг хамгаалах ба тогтвортой хөгжлийн арга зам" тесел, 6.1 сая ам доллар, 1998-2006
3. ДБХС-ийн санхүүжилтээр байгаль орчныг хамгаалах, ТХГН-ын менежментийг сайжруулах чиглэлийн жижиг теслүүд, жил бурийн 100 мянган щвейцар франк, 1998-2002

4. Голландын Засгийн газрын санхүү, техникийн дэмжлэгээр "Хустай нурууны байгалийн цогцолборт газрыг хамгаалах, менежментийг сайжруулах" тесел, 3.2 сая ам доллар, 1998-2002

5. АНУ-ын хөгжлийн агентлагийн санхүү, техникийн дэмжлэгээр "Хөвсгөлийн байгалийн цогцолборт газрыг бэхжүүлэх" тесел, 699 мянган ам доллар, 1999-2000

6. Европын холбооны ТАСИС хөтөлбөрийн хүрээнд "Байгаль орчин, хөдөө аж ахуйн мониторингийн систем" улс хоорондын тесел, 1999-2001

7. НҮБХХ, ЮНСО-ийн дэмжлэгээр "Байгаль орчны итгэмжлэлийн сан" тесел (Биологийн терөл зүйлийг хамгаалах, цөлжилттэй тэмцэх нэгдсэн сан)

Бэлчээр, газар ашиглалтын менежментийг сайжруулах, бэлчээрийн тахлдлыг баасгах, цөлжилтийн эрчийг сааруулах талаар

1. Данийн хөгжлийн агентлагийн (Данида) санхүүжилттэйгээр "Байгалийн нөөцийн менежмент, төлөвлөлтийн систем" тесел, 1.1 сая ам доллар, 1995-1997

2. ЦТК-ийн НБДГ-ын санхүүжилтээр цөлжилтэнд их нэрвэгдсэн нутагт (Говь-Алтай аймгийн Хөхморьт, Баян-Уул, Завхан аймгийн Дөрвөлжин сумд) ногоон бус байгуулах, шинээр худаг гаргах, ухуулга сурталчилгаа явуулах, цөлжилттэй тэмцэх албаны чадавхийг дээшлүүлэх чиглэлийн жижиг тесел, 15,0 мянган ам доллар, 1998

3. НҮБ ХХ-ийн хүрээнд Монгол улсын 21 дүгээр зууны хөтөлбөрийн санхүүжилттэй "Газрын менежментийг боловсронгуй болгох" (Дорноговь Замын Үүд) тесел, 35 мянган ам доллар, 1997-1998

4. Азийн хөгжлийн банкны дэмжлэгээр "Газрын бодлогыг бэхжүүлэх" тесел, 480 мянган ам доллар, 1996-1998

5. АХБ-ны дэмжлэгээр "Бэлчээрийн мал аж ахуйн үйлдвэрлэлийн системийн судалгаа" тесел, 600 мянган ам. доллар, 1996-1997

Үндэсний чадавхийг бүрдүүлэх, олон нийтийн мэдээлэл, сурталчилгааны талаар

1. Голланд улсын Засгийн газар, НҮХХ-ийн дэмжлэгээр "Байгаль орчны

мэдээлэл сурталчилгаа" төсөл, 397 мян. ам. доллар, 1996-1999

2. Азийн хөгжлийн банкны тусламжийн "Байгаль орчны удирдлагын чадавхийг бэхжүүлэх" төсөл, 569 мянган ам доллар, 1996-1997
3. Европын Холбооны ТАСИС хетелберийн хүрээнд "Байгаль орчны үйл ажиллагааны хетелберийг хэрэгжүүлэх, хэрэгжилтийг сайжруулах" төсөл, 1998-1999
4. АХБ-ны дэмжлэгээр "Хөдөө аж ахуйн салбарын чадавхийг бэхжүүлэх" төсөл, 800 мянган ам доллар, 1996-1997

Цөлжилтийн угтвар нөхцөл болох ойн неөцийн хомсдлын шалтгааныг тогтоож, бууруулах, ойг нөхөн үргүүлэх чиглэлээр

1. НҮХХ-ийн дэмжлэгээр "Ойг нөхөн сэргээх ба байгалийн гамшигийн менежмент" төсөл, 329 мянган ам доллар, 1996-1998
2. ХБНГУ-ын Засгийн газрын санхүүжилтээр "Түймрээс хамгаалах нэгдсэн менежмент" төсөл, 3 сая ДМ, 1997-2000
3. Японы Олон улсын хамтын ажиллагааны агентлагийн (ЖАЙКА) дэмжлэгээр "Сэлэнгэ аймгийн ойн неөцийн судалгаа" төсөл, 1993-1996
4. Япон улсын Хёого мужийн санхүүжилтээр "Ой мод үргүүлэх" төсөл, жил бүрийн 50 мянган ам доллар, 2000-2001

6. 1. 2. Засгийн газраас цаашид явуулах үйл ажиллагаа. Цөлжилттэй тэмцэх ажлыг бус нутгийн хэмжээнд эрчимжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх Ази номхон далайн бусийн сэдэвчилсэн б хетелбериин сүлжээний (СХС) "Гангийн нөлеөг бууруулах, цөлжилттэй тэмцэх чадавхи бүрдүүлэх" 5 дугаар сэдвийг Монгол улс хариуцах тухай хүсэлт саналыг ЦТК-ийн НБДГ-аас дэмжээд байгаа бөгөөд энэ талаар хэрэгжүүлэх теслийн бэлтгэл ажлуудыг зохион байгуулж эхлээд байна.

Монгол улсын Засгийн газар, ЦТУХор-ноос ХБНГУ-ын санхүү, техникийн туслалцаагаар урт хугацааны "Цөлжилттээс сэрэмжилэх менежментийн систем", "Ойг хамгаалах ойжуулах" теслийг.govийн бусийн 2 аймаг 2000 оны эхний хагас жилд эхлэн хэрэгжүүлэхээр төлөвлөж бэлтгэл, судалгааны ажлыг хийж байна.

Цөлжилттэй тэмцэх үндэсний хетелбериийн цаашдын хэрэгжилтийг хангах теслийн саналуудыг дэмжлэг авахаар тунш

орнуудад тавьж байна.

6.2. Түнш орнуудын хоорондын үйл ажиллагааны талаар албан бус зөвлөлдөх ба зохицох үйл ажиллагаа явуулах

Байгаль орчныг хамгаалах, цэлжилттэй тэмцэх, тогтвортой хөгжлийн бодлого, төслийн санал боловсруулах, бичиг баримт бэлтгэхэд Засгийн газрын холбогдох байгууллага бүрийн төлөөлөл, олон улс, хандивлагч орнуудын төлөөлөгчид оролцон санал солилцдог, зөвлөгөө өгдөг механизм тогтов.

Монгол улсын Засгийн газар Түнш орнуудын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах чиглэлээр энэ бүлгийн эхэнд дурьсан хандивлагчдын уулзалт, хоёр талын гэрээ, хэлэлцээрээс гадна манай улсад үзүүлж байгаа зээл тусlamжийн зохицуулалтыг сайжруулах, үр ашигийг нэмэгдүүлэх зорилгоор сэдэвчилсэн уулзалтуудыг түншлэгч орнуудын төлөөлөгчдийг оролцуулан зохион байгуулж байхаар шийдвэрлэсэн бөгөөд анхны уулзалтыг 1999 оны 11 сард "Засаглалын асуудал ба зээл тусlamж" сэдвээр зохион байгууллаа. Цаашдын төлөвлөгөөнд "Байгаль орчин, түүний тулгамдсан асуудлууд" сэдэв тусгагдсан бөгөөд энэхүү үйл ажиллагаа нь цэлжилттэй тэмцэх ажилд түншлэгч орнуудыг улам идэвхитэй татан оролцуулах, хоорондын үйл ажиллагааг зохицуулах, зөвлөлдөх механизмын нэг хэлбэр болж байна.

Түншлэгч, хандивлагч орнууд, олон улсын байгууллага болон үндэсний зохицуулагч байгууллага, үндэсний зохицуулагч нарын хооронд ажил төрлийн найрсаг холбоо тогтсон бөгөөд аливаа мэдээллийг шууд уулзаж ярилцах, санал солилцох, шаардлагатай мэдээлэл, ном товхимол хүргэх, төслийн урьдчилсан санал хүргүүлэх, хүсэлтийн тавих зэрэг хэлбэрээр ажилладаг уламжилтай болсон. Мен суулийн үед мэдээлэл солилцоход интернетийн вэб хуудсыг ашиглах механизмыг хэрэглэхээр туршиж байна.

Жил бүр зохиогддог ЦТК-ийн талуудын бага хурал, бусад уулзалт, семинар, зөвлөгөөний үеэр үндэсний зохицуулагч, болон түүний төлөөлөгч нар түншлэгч улс орон, байгууллагын төлөөлөгчидтэй биечлэн уулзаж ярилцах, тохиролцох, хамтран ажиллах хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулж байна. Мен эх орондоо байгаа холбогдох хандивлагч орны элчин сайдын яам, консул болон төрийн байгууллагын өндер түвшний хүмүүсийн уулзалт, айлчлалын үеэр тодорхой асуудал, төслийг ярилцан шийдвэрлэдэг. Янз бүрийн түншүүдэд тодорхой үүрэг зорилгыг хуваарилдаггүй бөгөөд тухайн үед нь хамтарч ярилцаж, харилцан шийдвэрлэдэг.

**7. ГАН, ЦӨЛЖИЛТИЙН МОНИТОРИНГ ХИЙХ, ҮНЭЛГЭЭ ӨГӨХ
ЗОРИЛГООР ЦӨЛЖИЛТТЭЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ
ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ТҮҮНИЙ ДОТОР ЭДИЙН ЗАСГИЙН
ОРЧНЫГ САЙЖКРУУЛАХ, БАЙГАЛИЙН БАЯЛГИЙГ
ХАМГААЛАХ, ТОГТВОРТОЙ АШИГЛАХ, БҮТЭЦ ЗОХИОН
БАЙГУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ, ЦӨЛЖИЛТ,
ТҮҮНД ХЯНАЛТ ТАВИХ МЭДЛЭГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ
ТАЛААР ТӨЛӨВЛӨСӨН БОЛОН АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН
АРГА ХЭМЖЭЭНҮҮД**

7.1.Өмнөх туршлагын оношлогоо

7.1.1.Монгол орон дахь цөлжилтийн өнөөгийн байдал. Монгол орон Евразийн эх газрын төвд гадаад далай тэнгисээс ихээхэн алс, далаин түвшнээс дунджаар 1580 м өндөрт өргөгдсөн, ихээхэн хуурай уур амьсгалтай, хөрсний үржил шим дорой, ургамал нэмрөгөөр ядуулаг бөгөөд, нийт нутгийн 41.3 хувь нь Төв Азийн говь целийн бүсэнд хамарагдана.

Монгол улс 156411.6 мянган га газар нутагтай, үүнээс 121.9 сая га газрыг ХАА-д(125.7 га газрыг бэлчээрт, 952.9 мянган га-г газар тариаланд, 2045.4 мянган га-г хадланд) ашиглана.

Монгол орны газар нутгийн 78.2% нь цөлжилтэнд өртөх боломжтой, үүнээс 59.4% нь нэн эмзэг нутаг. Одоогоор бэлчээрийн 70 гаруй хувь элэгдэлд орсны дотор 64306.1 мянган га /50.8%/ нь дунд зэргийн, 26027.4 мянган га 20.7% их, 1814.5 мянган га/1.4%/ бэлчээр нэн хүчтэй талхлағдаад байна.

Сүүлийн 40 гаруй жилийн дотор их талхлагдсан бэлчээрийн ургац 5 дахин буурч, ургамлын зүйлийн тоо 6 дахин цеөрч, хөрсний биологийн чадавх нэн доройтсон байна. 1970-1990 оны хооронд цэл, целерхөг хэзэрийн бүсийн бэлчлээрийн ургамлын зүйлийн тоо 33-аас 18 болж га-гийн ургац 0.32-оос 0.23 т/га болтол буурав.

Монгол орны нутагт 42.2 мянган ам.км талбайд элс тархасны 3800 ам.км талбай нь 1940 оноос хойш шинээр элсжсэн байна.

Монголын өмнөд говьд целийн бүсэнд элсэн манхнууд жилд 20 м хурдтай нүүж бэлчээрийг элсээр дарсаар байна.

Монголын говь целийн бүсэнд 1960-аад онд жилд 16 өдөр широо шуурч байсан бол 70-аад онд 23 өдөр, 80-аад онд 41 өдөр болж нэмэгдсэн байх юм.

Монгол оронд 1960-аад оноос их хэмжээний атар газрыг хагалж /1.3 сая га/ газар тариалан хөгжүүлж ирсэн боловч ерээд оны дунд үе гэхэд тариалангийн эргэлтийн талбайн 46.5% нь /561.5 мян.га/ элэгдэлд орсон, үүнээс 158.4 мянган га /28.2%/ нь дунд зэргийн, 72.4 мягган га/1.9%/ нь хүчтэй элэгдэлд оржээ. Тариалангийн талбайн

хөрсний ялзмаг 21.3%-иас /дунд зэргийн элэгдэл/39.4% хүчтэй элэгдэлд орсон/буурсан байна. Үүнээс болж улаан буудайн ургац харгалзан 30.6%-66.0% буурчээ.

Монгол орны нутаг дэвсгэрийн 8.3 хувийг ой зэлэх боловч 1974-1998 оны хооронд ойн сангийн талбай 1.4 сая га-гаар хорогдсон нь мод бэлтгэл, түймэр, ойн хөнөөлт шавьжтай холбоотой. Говь целийн бүсийн 4.5 сая га талбайд хөрс хамгаалах чухал үүрэгтэй заган ой тархсан боловч байгалийн хуурайшил, хүний үйл ажиллагааны улмаас залуу дунд насны заган ойн талбай буурсаар байна.

7.1.2. Цөлжилтийн хүчин зүйл. Монгол оронд нүүрлэж байгаа цөлжилтийн шалтгаан:

- **Байгалийн**
- **Хүний үйл ажиллагааны**

гэж 2 хувааж болох боловч энэ хоёр хүчин зүйл харилцан сүлжилдсэн зарим үед бие биенээ тэтгэх, зарим үед харилцан бие биенээ бууруулах байдлаар үлчилнэ. Байгалийн хуурайшилтын дэвсгэр дээр цөлжилтийг нөхцөлдүүлэх хүний үйл ажиллагааны хүчин зүйл давхцсанаар ихээхэн серег үр дагавар авчирч байна.

A) Байгалийн хүчин зүйл

Монгол орны сүүлийн 500-аад жилийн уур амьсгалын хэлбэлзлийг судалж үзэхэд (Gordon Jacoby ба бусад, 1996) хуурайших буюу чийгших тал руугаа нэг чигтэй өөрчлөлт явагдаагүй боловч тодорхой хугацааны дотор уур амьсгал тодорхой хэмжээгээр хэлбэлзэж ирсэн байна. Сүүлийн 60 жилийн цаг уурын ажиглалтын мэдээгээр дечеөд оны дунд үе, наяд оны үед хэд хэдэн жил дараалан хур тунадас татруу орж гангийн эрчим нэмэгдэж байлаа. Монгол орны нутгийн 50-иас дээш хэсгийг хамарсан зуны ган 10 жилд 1-2 удаа тохиолддог бол 1941-1950 он, 1981-1990 онд тус бүр 3-4 удаа тохиолдож наяд оны дундуур олон горхи булаг ширгэж хөрсний ус доошилж говийн зарим нуурууд ширгэж байлаа.

Харин хаврын улиралд чийг дутмлаг, бараг жил болгон гантай юмуу гандуу байдаг.

Жилийн нийлбэр хур тунадас сүүлийн 60 жилийн дотор 6% орчим нэмэгдсэн, үүнээс хур тунадасны 50-60% нь ордог зуны 3 сард 11%-иар нэмэгдсэн, харин хаврын хур тунадас 17%-иар буурсан байна. Сүүлийн 60 жилийн дотор Монгол орны жилийн дундаж агаарын температур 1.56°C -аар үүний дотор өвлүүн улиралд 3.61°C -аар, хавар, намрын улиралд $1.4-1.5^{\circ}\text{C}$ -аар тус тус дулаарсан байна. Хур тунадас температурын олон жилийн явцаас харахад хаврын сүүлч үе рүү /Y

сард/ хур тунадас огцом буурч ихээхэн дулаарч байгаа нь харагдана.Хамгийн хуурай хаврын улиралд /цөлийн бүсэнд өдрийн цагт харьцангуй чийгшил 15-20% болно/ хамгийн их салхитай улирал давхцдаг. Монгол орны цөлийн бүсэнд жилд 60 өдрөөс олон,целерхөг хээрийн бүсэнд 30-60 өдөр шороо хийсэх бөгөөд Монгол элсний урд захад /Завханы Дорволжин/ жилдээ 120 өдөр шороо шуурдаг. 1960-1998 оны хооронд Монгол оронд шороо хийсдэг өдрийн тоо 3-4 дахин ихэссэн баримт бий.

Б) Хүний хүчин зүйл

Цөлжилтөнд хүргэж байгаа хүний хүчин зүйл голдуу байгалийн хүчин зүйлийн дэвсгэр дээр түүнийг идэвхижүүлэх нелээтэй байх нь элбэг. Цөлжилтийг нэхцэлдүүлж байгаа хүний хүчин зүйлийг бэлчээр болон тариалангийн талбай, хот тосгоны эдэлбэр газрын хувьд тус тусад нь авч үзэх нь зохистой.

Тариалан эрхэлж ирсэн сүүлийн 40 жилийн хугацаанд херс боловсруулах технологи Монгол орны херс, уур амьсгалын онцлогт тэр бүр нийцэхгүй байгаатай гол нь холбоотой.

Тариаланд зориулан хагалсан 1.3 сая га талбайнхаа 565.0 мянган га-г сүүлийн 10 жилд атаршуулан хаяж одоо жил бүр 500.0 мянга га зргэлтийн талбайд тариалалт эрхлэж байна. 1998 оны мэдээгээр Монгол улс тариаланд тохиромжтой херснийхөө 84.0%-ийг хагалсан боловч түүний 30.0 хүрэхгүй хувийг зргэлтэнд, үлдэх хувийг атаршуулан хаяд байна. Үүний гол шалтгаан нь тариалалт явуулах хөрөнгө менгэ хомсоос гадна гол нь херсний үржил шимийн доройтол болно.

Бэлчээрийг цөлжилтөнд хүргэж байгаа хүний хүчин зүйл олон янз. Үүнд:

- Бэлчээр ашиглах уламжлалт технологи алдагдсан. Сүүлийн 70 гаруй жилийн дотор мал сургийн тоо/1924 онд 13.7 сая толгой байсан бол 1999 оны эцсээр 33 сая болсон/эрс өссөн байхад бэлчээрийн талбай 20% багассан.
- Бэлчээрийн усан хангамж хүрэлцээгүй. Сүүлийн 10 гаруй жилийн дотор бүрч дордсон. Судалгаанаас үзвэл уст цэгийн эргэн тойрон 1-3 км радиуст бэлчээр ихээр талхлагддаг.
- Говийн бүсийн модлог ургамал, түүний дотор загийг түлшинд хэрэглэх, нуурын зэгсийг нэлд нь хадаж тэжээнд ашиглах зэргээр элсний нүүлт

идэвхжсэн.

- Хөрсний техноген элэгдэл жараад оноос идэвхжсэн. Цэргийн хүнд техник хеделгээн, цэргийн сургуулилтын явцад 600 мянга талбайн хөрс эвдэрсэн.
- Уул уурхайн үйл ажиллагааны явцад хөрс эвдрэх явдал нилээд хэмжээтай, нөхөн сэргээлт бараг хийгдэхгүй байна. Орхон Сэлэнгийн сав газарт алт олборлох 120-иад аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны явцад 2 сая тн тэжээлийн нөөц бүхий хөрс эвдэрсэн тооцоо байна.

Монгол орны цөлжилтийн байдалд хийсэн дээрх оношлогоо, дүгнэлт нь Цөлжилттэй тэмцэх үндэсний хетэлбер /ЦТҮХ/-ийг боловсруулах, түүний гол стратегийг тодорхойлох, гол гол асуудлын зэрэглэлийг тогтооход үндэслэл боллоо.

Энэхүү оношлогоо, дүгнэлтийг олон жилийн туршид явуулсан териийн бодлого, үйл ажиллагаа, түүнээс газрын ашиглалт хамгаалалтанд үзүүлсэн нөлөөлөл, нийгэм, эдийн засгийн нөхцөлтэй уялдаатайгаар тогтоосон болно. Оношлогоо дүгнэлтийн талаар хэд хэдэн цуврал судалгааны теслийг хэрэгжүүлж, үр дүнгээр нь ярилцлага, хурал, уулзалт, семинар зохион байгуулж эсцийн дунд нийтэд хүлээн зөвшөрөхүйц үнэлгээ дүгнэлтийг гаргасан билээ.

Дээрхи 7.1.1, 7.1.2-д авч үзсэн оношлогоо, үнэлгээ, дүгнэлтийг ЦТҮХ-ийг боловсруулахад гол үндэслэл болгож, уг хетэлberийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ, теслүүдийг боловсруулах болно.

7.1.3. Цөлжилттэй тэмцэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний үнэлгээ

Монгол орны цөлжилтийн өнеегийн байдалд оношлогоо хийснийхээ үндсэн дээр түүнтэй тэмцэх олон талт үйл ажиллагааг далаад оны дунд үеэс эхлэн төр засгийн бодлогын түвшинд хэрэгжүүлж эхэлсэн боловч энэ нь цөлжилтийн эрчмийг сааруулахад төдий лүр дүн өгч чадаагүй юм. Үүний шалтгаан нь хөрөнгө санхүүгийн нөөцийн хомсдол, техник технологийн хоцрогдол, эрх зүйн орчны дутагдал гол нь газар өмчлөл, эзэмшлийн асуудал бараг өнеөг болтол шийдэгдээгүйтэй холбоотой. Монголчуудын уламжлал ёсоор хэдийнээс нааш нийтийн эзэмшил байдлаар газар ашиглаж ирсэн бэлчээрийн МАА-н онцлогоос болж жилийн 4 улирлын турш нүүж бэлчээр сэлгэж байдаг онцлог нь газар ашиглалтыг шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулахад саад болдог. Хэдийгээр хот суурингийн газар түүний ойр орчим, газар тариалангийн газрыг өмчлүүлэх, эзэмшүүлэх боловжтой боловч нийгмийн сэтгэхүйн уламжлал одоо болтол саад болж байна.

Байгаль орчны яамнаас сүүлийн 10 жилийн дотор байгалийн нөөцийг зохистой ашиглах, байгаль орчныг хамгаалах болоод цэлжилттэй тэмцэхтэй холбогдсон иж бүрэн хууль эрхэүйн актуудыг боловсруулан гаргах, гүйцэтгэх засгийн хүрээнд хэрэгжүүлэх нилээд тооны хөтөлбөрүүд түүний дотор "Цэлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр"/1996 он/-ийг баталсан нь газрын менежментийг сайжруулах, газрыг доройтлоос сэргийлэх, хөрсний элэгдлийг бууруулах хэрэгт улсын төвлөрсөн төсөв, гадаад дотоодын төслүүдээс нилээд хөрөнгө хүч дайчлах боломжийг бүрдүүлсэн юм.

7.2. Цэлжилттэй тэмцэх техникийн хөтөлбөрүүд ба хэрэгжиж буй цогцолбор төслүүд.

ЦТҮХ-т нийцүүлэн байгалийн нөөцийн менежмент, цэлжилтийн мониторинг, цэлжилттэй тэмцэх чиглэлээр хэрэгжиж байгаа бодлого, үйл ажиллагаанд ЦТҮХорооноос үнэлгээ дүгнэлт өгч, Байгаль орчны яамны бодлого, хөтөлбөрүүдэд өөрчлөлт хийсэн болно.

Ингэснээр ЦТҮХ-ийг хэрэгжүүлэхэд гадаад түншүүдийн санхүүгийн тусламжтай хэрэгжүүлэх төслүүд болон үндэсний хэмжээнд бодлого зохицуулалтыг өөрчлөх, шинэчлэх, дотоодын санхүүгийн нөөцийг зохистой ашиглах зэрэг чиглэлээр нилээд алхам хийлзээ.

7.2.1. ЦТҮХ-ийн хү рээнд хэрэгжиж буй бусад чиг бодлого хөтөлбөрийн төрлүүд, тэдгээрийн үр дүн. Монгол улсын Засгийн газраас 1996 онд "Цэлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийг батлан гаргаснаас хойш түүнтэй уялдаатайгаар Ойн тухай, Усны тухай, Байгалийн гамшгийн аюулыг бууруулах тухай, Бүх нийтэд экологийн боловсрол олгох тухай г.м цэлжилттэй тэмцэх үйл ажиллагаанд холбогдох олон тооны хөтөлбөрүүд боловсруулан хэрэгжүүлж байгаагийн дээр "Монгол улсын ХХI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр" г.м урт хугацааны үзэл баримтлал, хөтөлбөрүүдэд цэлжилтийг бууруулах асуудал өргөн хүрээтэй туссан болно. Дээрхи хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд дотоодын санхүүгийн нөөцийг дайчлан дараах арга хэмжээг авч хэрэгжүүллээ. Үүнд:

- Байгалийн нөөц ашиглалтын төлбөрийн тухай хуулиудад орлогын тодорхой хэсгийг байгалийн нөөцийг нөхөн сэргээхэд зарцуулдаг боллоо.
- 1950-1960 онд жил бүр 1000-6000 шоометр загийг тулшинд хэрэглэж байсан бол ерээд оноос хойш загийг зөвхөн малчдын түлшний

хэрэгцээнд бага хэмжээгээр ашиглах болов.

- Говьд заг, сухай, жигд, тоорой зэрэг мод, модлог ургамлыг тарималжуулах судалгаа туршилт хийгдэж байна.
- Ойг нехен сэргээх ажлыг эрчимжүүлж ирснээр сүүлийн 4 жилд 18000 гаруй га талбайд ойжуулалт хийж, улсаас 170 орчим сая төгрөг зарцууллаа. 1998 онд 370 гаруй мянган га-д чацааргана, үхрийн нүд зэрэг жимс жимсгэнэ, мод сөөг ургуулж байна. Ойгоос бэлтгэх модны хэмжээг 1990-аад оноос бараг 3 дахин бууруулж чадлаа.
- Атаршиж эргэлтээс хасагдсан тариалангийн талбайд олон наст ургамал тарих, олон наст ургамлын зурvas байгуулах ажил бага ч гэсэн хийж байна. Сэлэнгэ аймгийн Орхон суманд 1996-1998 онд хүчтэй элэгдэлд орсон 600 га талбайд олон наст ёвсний зурvas тарьж мөн элжсэн 200 гаруй га-газарт олон наст тариалав.
- Сүүлийн 5 жилд 20 гаруй булаг шандыг тохижуулж ундаргыг сайжрууллаа.
- Монгол орны ойн 400.0 мян.га талбайд тархсан ойн хөнөөлт шавьжны судалгааны ажил хийж 2250 га талбайд хөнөөлт шавьжны устгал хийлзээ.
- Ашигт малтмалын орд ашиглалтын явцад эвдэрсэн орчныг нехен сэргээх ажилыг системтэй хийдэг болж сүүлийн 3 жилд 3.5 сая орчим га талбайг хамруулсан байна. Гэвч энэ нь эвдэрч сүйдсэн газрын дөнгөж 30-хан хувийг эзэлж байгаа юм.
- Дорноговийн Замын-Үүд, Говь-Алтайн Хөхморьт сумдад элсний нүүдэл идэвхжсэн газарт нехен сэргээлтийн ажил эрчимтэй хийж байна.
- Ой хээрийн түймэртэй тэмцэх, түймрээс

сэргийлэх ажлын далайц улам тэлж 1996 онд 368 түймэр гарч байсан бол 1997 онд 219, 1998 онд 132, 1999 онд 120 удаа ой хэзрийн түймэр гарч тоо нь жилээс жилд буурч байна.

- Цөлжилттэй тэмцэх шинэ үйл ажиллагааны талаар дараах арга хэмжээг санал болгон хэрэгжүүлж байна. Үүнд:
 - газрын шинэлгэл хийх, газрын менежментийг сайжруулахад чиглэсэн бодлого, эрх зүйн орчныг бүрдүүлэх.
 - байгалийн нөөц ашигласны төлбөрийн тогтолцоо бий болгож, төлбөрийн тодорхой хэсгийг газрыг хамгаалах, нехэн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэх.

7.2.2. Цөлжилттэй тэмцэх үндэсний чадавхийг бэхжүүлэх талаарх арга хэмжээ

Цөлжилттэй тэмцэх чадавхийг бэхжүүлэх талаар дараах арга хэмжээг авав.

- Орон нутгийн төлөлөгчид, ойжуулагч, тариаланчдад зориулан сургалт, семинар зохион байгуулах
- Тодорхой хөтөлбөр, техникийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх .
- Олон улсын төслийг хэрэгжүүлж чадавхи бий болгох

зэрэг арга хэмжээг авав. Эдгээрийг тус бурд нь авч үзье.

A /Сургалт, семинар

Ойжуулагч, тариаланчдад зориулан хамтын эзэмшлийн ой бий болгох, газар тариалангийн технологийг сайжруулах талаар 1996-1999 онд 8 удаа сургалт семинар, уулзалт хийж давхардсан тоогоор 3000 илүү хүмүүсийг хамруулав. Мөн ой хэзрийн түймрээс сэргийлэх, түймрийг богино хугацаанд унтраах асуудлаар орон нутагт бүсчилсэн семинар 4 удаа, бусад сургалт 6 удаа зохион байгуулж орон нутгаас 5000 гаруй хүмүүсийг оролцуулав.

Бэлчээр нутгийг зохистой ашиглах чиглэлээр 6 удаа сургалт

семинарыг орон нутагт зохион байгуулж, 1000 илүү хүмүүсийг хамруулав.

Б/Техникийн хөтөлбөр

- "Ногоон хувьсгал" хөтөлбөр
- "Ойн тухай үндэсний хөтөлбөр
- "Усны үндэсний хөтөлбөр"

зэрэг хэд хэдэн үндсэн хөтөлбөрийг Засгийн газар батлан гаргав.

"Ногоон хувьсгал" хөтөлбөр нь орон нутагт олон нийтийг газартай харьцаж сургах, хувиараа газар тариалан эрхэлж, амьдрал ахуйгаа дээшлүүлэх зорилготой юм.

"Ойн тухай үндэсний хөтөлбөр" нь ойг зохистой ашиглах, хамгаалах, ойжуулах, ойн түймэр, хенеөлт шавьжаас сэргийлэх, нийтийн эзэмшлийн ой бий болгоход олон нийтийн оролцоог дээшлүүлэх зорилготой.

"Усны үндэсний хөтөлбөр" нь.gov, хээрийн бүсэнд гадаргын усгүйгээс ашиглаагүй байгаа бэлчээр нутгийг усжуулах / худаг гаргах/, хот суурины хүн амын усан хангамжийг дээшлүүлэх зорилготой.

В/Олон улсын төсөл хэрэгжүүлэх:

1996-1999 онд дараах төслийг хэрэгжүүлж үндэсний чадавхийг бэхжүүлэв. Үүнд:

- ДАНИДА, "Байгалийн неецийн менежмент, төлөвлөтийн систем"
- НҮБ ХХ: "Ойг нехэн сэргээх ба байгалийн гамшигийн менежмент"
- ХБНГУ,GTZ: "Ой, хээрийн түймрээс сэргийлэх".

Эдгээр төслүүдийн хүрээнд нийтдээ 20 гаруй удаа орон нутгийн хүмүүсийг оролцуулан сургалт явуулж, бодит үр дүнд хүрлээ.

Цэлжилттай тэмцэх үндэсний чадавхийг буй болгоход ихээхэн анхаарал тавьж байна. Энд ялангуяа ой хээрийн түймэртэй тэмцэх, гэрийн тариалан эрхлэх, хөрсний техноген элэгдлээс сэргийлэх, хөрсийг нехэн сэргээх чиглэл дээр тодорхой амжилт олиж байна. Энэ нь ой хээрийн түймрийн хамрах талбай жилээс жилд буурч байгаагаар илрэч байна. Энэ үйл хэрэгт Холбооны Бүгд Найрамдах Герман Улсаас 1998 оноос эхлэн хэрэгжүүлж байгаа "Ой, хээрийн түймрээс сэргийлэх

нь" төсөл чухал үүрэг гүйцэтгэж байна. 1996 онд батлан гаргасан "Ой хээрийн түймрийн тухай" хуулиар иргэд, орон нутгийн засаг захиргааны байгууллага, иргэдийн хүлээх үүрэг, хариуцлагыг чангатгасан явдал зохих ач холбогдоо егч байна.

Ойг нехен сэргээх чиглэлээр хэдэн арван мод үржүүлгийн газар ажиллаж энд тавих хяналт, санхүүжилт сайжирлаа.

Монгол улсын Засгийн газраас 1997 оноос эхлэн хэрэгжүүлж байгаа "Ногоон хувьсгал" хөтөлбөрийн хүрээнд иргэдийн газартай харьцах соёл илт дээшилж, ядуурлыг бууруулах ажлыг байгаль хамгаалах ажилтай холбосон чухал арга хэмжээ боллоо.

Замын-Үүд, Хөхморьтын районд элсний нүүлттэй тэмцэх ажлыг олон улсын хөрөнгө, санхүүгийн дэмжлэгээр эхлэн хэрэгжүүлэв.

7.3.Үйл ажиллагааны хөтөлбөрүүдийн конвенцийн заалтад нийцэх нь.

7.3.1. Цөлжилттэй тэмцэх бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгож байгаа нь. Цөлжилттэй тэмцэх бодлого, үйл ажиллагааны үндэсний хүрээн дэх зохицуулалт одоогоор төдийлен сайн бус байна. Энэ ажлыг цөлжилттэй тэмцэх Үндэсний хорооны хүрээнд зохион байгуулж байгаа боловч эрхзүйн статус тодорхой бус, өөрийн бие даасан санхүүжилтгүй учир улсын төсвийг хуваарилахад санал өгөх төдий хэмжээнд оролцож байна.

Цөлжилттэй тэмцэхэд орон нутаг, иргэдийн оролцоо сул, гол нь төр засгийн төв байгууллагаас зохион байгуулсан хэвээр байна. Малчид зөвхөн бэлчээр нутгаа ашиглах уламжлалт арга хэрэглэсээр байна. Газар зохион байгуулалтын шинэ менежмент дутагдалтай байна. Төрийн бус байгууллагуудын оролцоо одоогоор төсөл хэрэгжүүлэхээс хэтрэхгүй байна. Энэ бүгд байгаль хамгаалах байгууллага, байгаль ашиглах байгууллага, иргэдийн хоорондох харилцааны зохих дэг тогтоогүй, төрийн захиргааны төв байгууллагуудаас эхлээд орон нутгийн засаг захиргаа, өөрөө удирдах ёсны байгууллага хүртэл аж ахуйн байгууллагуудтай хэрхэн ажиллас арга механизм тогтоогүй, газар өмчлөлт, эзэмшилтийн асуудал шийдвэргээгүйтэй гол нь холбоотой.

Дээрхи байдалд үнэлгээ, дүгнэлт өгсний үр дүнд бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох зорилгоор 1997 онд Газар зохион байгуулалтын албыг байгуулж, түүний харьяа албадыг орон нутагт байгуулав. Ингэснээр орон нутагт газрын харилцааг зохицуулах, газрыг иргэдэд эзэмшүүлэх ажлыг эрчимтэй хийж эхэллээ. Мөн 1997 онд Газрын төлбөрийн хуулийг баталж, 1999 онд нэмэлт оруулснаар газрыг хамгаалах, нехен сэргээх эдийн засгийн үндэслэл бүрдэж эхэллээ.

7.3.2. Ган, цэлжилтөд хяналт шинжилгээ хийх, үнэлгээ өгөх арга хэмжээ

Ган, цэлжилтөнд хяналт тавих үйл ажиллагааг ус цаг уур, орчны шинжилгээний өртөө, харуул болон Монгол улсын Шинжлэх ухааны байгууллагууд түүний дотор ШУА-ийн байгууллагууд хийж байна. Энэ үйл хэрэгт Монгол улсын нутаг дээр дочеөд жил үйл ажиллагаа явуулсан Монгол-Зөвлөлтийн ШУА-ийн Монгол-Зөвлөлтийн биологийн иж бүрэн экспедици томоохон үүрэг гүйцэтгэж Цэлжилтийн зураг хийсэн байна.

Монгол оронд тохиолдог гангийн мониторингийг Үндэсний Ус цаг уурын алба эхлэн гүйцэтгэх ба энд газрын болон сансрын техник хэрэгсэл хослуулан ашигладаг. Ус цаг уурын хүрээлэнгээс дулаан улирлын арав хоног бүрт цаг уурын ЗОО гаруй өртөөн дээр хийсэн бэлчээрийн ургацын үнэлгээгээр ган, зүвшлагын зураглал үйлдэн үүнийгээ сансрын мэдээллээр тодотгон гаргагдаг.

ХАА-д бэлчээрийн мал аж ахуйд зонхилох үүрэгтэй Монгол орны хувьд гангийн шуурхай хяналт шинжилгээ хийх нь улс орны эдийн засгийн талаас чухал ач холбогдолтой юм. Зун нь ган болбол ирэх өвөл нь цас их, бага байснаас бараг үл хамааран малын хорогдол үзэмж их болдог онцлогтой.

1999 онд "Газрын кадастрын зураглалын хууль" батлагдсан нь газрын төлөв ялангуяа цэлжилтөнд хяналт, шинжилгээ хийх чухал эрх зүйн орчинг бүрдүүлэхэд чухал хувь нэмэр болох юм.

7.3.3. ЦТҮХ-ийг хэрэгжүүлэхийн тулд эдийн засгийн орчныг сайжруулах арга хэмжээ: Энэ чиглэлээр Засгийн газраас 1996-2000 онд дараах арга хэмжээг авав. Үүнд:

- Бүх төрлийн бүтээгдэхүүний үнийг чөлөөлж зах зээлийн харилцаанд шилжүүлэв.
- Түлш, эрчим хүчний үнийг чөлөөлев.
- Инфляцийг З дахин бууруулав.
- Татварын шаталалыг цөөрүүлэв.
- Мод, модон бүтээгдэхүүний экспортод гаалийн өндер татвар тогтоов.
- Байгалийн нөөц ашигласны төлberийн орлогоос байгаль орчныг хамгаалах, цэлжилттэй тэмцэх арга хэмжээнд зориулан ашиглах тухай хууль санаачлав.

7.4. Дэд бус, бусийн хамтын ажиллагааны хөтөлбөрүүдтэй уялдах нь

Монгол улсын ЦТҮХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээг Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссын Цөлжилттэй тэмцэх нэгжийн үйл ажиллагаа, бүс нутгийн хөтөлбөр болон дэд бүсийн хамтын ажиллагааны хүрээний тесел, үйл ажиллагатай нягт уялдаатай явуулж байна. Тухайлбал Азийн бүсийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд сэдэвчилсэн хөтөлбөрийн сүлжээний "Гангийн нелеөг бууруулах, цөлжилттэй тэмцэх чадавхийг бэхжүүлэх" сэдвийг Монгол улс хариуцан гүйцэтгэх бэлтгэлийг хангаж байна. Мен Зүүн хойд Азийн байгаль орчны хамтын ажиллагааны хүрээнд цөлжилттэй тэмцэх, газрын доройтлыг бууруулах арга хэмжээнд оролцож байна.

Монгол улс цөлжилтийн судалгаа, түүнд хяналт шинжилгээ хийх, цөлжилтийг сааруулах арга хэмжээний хүрээнд Төв Азийн бүсийн хөрш зэргэлдээ улс орнууд, Ази, Зүүн Азийн бүсийн олон талын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож байна.

Олон улсын "Геобиосфер" хөтөлбөрийн хүрээнд Зүүн хойд Азийн газар ашиглалт, бүрхэвчийн өөрчлөлт теселд оролцож байна. Энэ төслийн эхний шатанд мэдээллийн сан бүрдүүлэх ажил хийгдэж байгаа ба 1992 оны байдлаар газрын бүрхэвчийн зураг хийгдсэн болно. Төслийн хүрээнд өөрчлөлт болж байгаа эсэх, түүний хүчин зүйлүүд юу болох, цаашдын хандлагыг тогтоох зэрэг судалгааны ажлууд хийгдэв.

7.5. Орон нутгийн чадавхи буй болгох арга хэмжээний үр ашиг

Орон нутагт газрын менежментийг сайжруулах, цөлжилттэй тэмцэх чадавхийг буй болгохын тулд 1997 оноос эхлэн жил бүр орон нутгийн газрын менежерүүдэд зориулж 7-14 хоногийн сургалт семинар зохион байгуулж байна. Үүний үр дүнд орон нутагт газрын тооллого, бүртгэл хийж, газрын доройтлоос сэргийлэх, доройтолтой тэмцэх арга хэмжээг авч байна. Орон нутагт байгалийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, хяналт тавих бие даасан үйл ажиллагааг хангахын тулд аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын эрхийг өргөтгэх, тэдний чадавхийг дээшлүүлэх семинар, сургалтыг удаа дараа зохион байгуулж холбогдох гарын авлага, ном товхимолоор хангаж байна.

7.6. Түншлэлийн гэрээнүүд

Монгол улсад газар, ой, ургамлын нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээг төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа түншлэлийн хүрээнд газрын хууль, газрын кадастрын хууль болон бусад эрх зүйн орчинд зохих гэрээ, хэлэлцээр байгуулан хэрэгжүүлж байна. Газрын болон байгалийн баялгийг эзэмших, ашиглах гэрээг орон нутгийн засаг захиргааны байгууллага зохицуулдаг.

Монгол улс 1994 оноос эхлэн ЦТҮХ-ийг хэрэгжүүлэхэд ЮНЕП, ЮНДП, ЮНСО, НҮБ-ийн ХХААБ, Азийн хөгжлийн банк г.м олон улсын байгууллагууд, Япон, Холбооны Бүгд Найрамдах Герман, Дани, Нидерланд зэрэг улстай хоёр талын гэрээ хэлэлцээрүүдийн үндсэн дээр төсөл хэрэгжүүлж зохих үр дүнд хүрч байна.

**8. ЦӨЛЖИЛТТЭЙ ТЭМЦЭХ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ
ДЭМЖИН ҮНДЭСНИЙ ТӨСВӨЕС ХУВААРИЛСАН
САНХҮҮЖИЛТИЙН ХЭМЖЭЭ, ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА
ХИЙГЭЭД САНХҮҮГИЙН БОЛОН ТЕХНИКИЙН ХАМТЫН
АЖИЛЛАГАА, САНХҮҮЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛ, АЧ
ХОЛБОГДЛЫН ЗЭРЭГЛЭЛ**

8.1 Хэрэглэж байгаа санхүүгийн механизм

Монгол улс зах зээлийн эдийн засгийн шинэ харилцаанд шилжих байгаатай холбогдон нийгэм эдийн засгийн бухий л хүрээнд эрх зүйн тогтолцоог шинэчлэн хуульчилж, 1994-2000 онд байгаль орчныг хамгаалах, неөц баялагийг зохицой ашиглах, нехэн сэргээх талаар 22 хууль, 200 орчим эрх зүйн актыг батлан мөрдеж байна. Байгаль хамгаалах тухай хуулийн 33-р зүйлд " Төрийн болон нутгийн вөрөө удирдах байгууллагаас байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавихад шаардагдах зардлыг улсын төвлөрсөн болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ" гэж заасан билээ. Энэ заалт нь байгаль орчныг хамгаалах, цөлжилттэй тэмцэх ажлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг хуульчилж өгсөн хэрэг. Цөлжилттэй тэмцэх хүрээнд хамаарах салбарууд, тухайлбал хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, дэд бүтэц, нийгмийн хамгааллын салбарын шууд болон шууд бус хөрөнгө оруулалтын зарим хэсгийг тооцох нь зүйтэй.

Цөлжилттэй тэмцэх ажлын санхүүжилт болон менежментийн үйл ажиллагаанд янз бүрийн оролцогч талуудын оролцооны журмыг хуулиар зохицуулсан болно.

8.1.1 Улсын төсвийн санхүүжилтийн эх үүсвэр , орон нутгийн оролцогч талуудад олгож байгаа нь. Үндэсний төсвөөс байгаль орчныг нехэн сэргээх, цөлжилтийг сааруулах ажлын хүрээнд 1997-1999 онд хуваарилан олгосон хөрөнгийн хэмжээг хүснэгт 2-д үзүүлэв.

**Хүснэгт 2. Үндэсний төсвөөс байгаль орчныг
нөхөн сэргээх, цөлжилтөөс сааруулах ажлын хүрээнд
хуваарилан олгосон хөрөнгийн хэмжээ, сая төгрөг**

	Зардлын төрөл	1997	1998	1999
1	Бэлчээрийн талхагдлыг багасгах зорилгоор хуучин худгудыг сэргээн, шинэчлэн төхөөрөмжлөх	-	240,0 **	282,0 **
2	Хөдөөгийн төв, суурингийн усан хангамжийн эх түсвэрэйн судалгаа ***	86,0	200,0	88,0
3	Ойжуулалт, ойн арга хэмжээ (ой зохион байгуулах, нөхөн сэргээх, хамгаалах, үр үргүүлэг г.м)	172,0	165,0	240,0 ****
4	Дархан газар /доройтолд өртсөн орчинг сэргээн сайжруулахад/	96,2	119,7	138,7 ****
5	Жижиг теслүүд	13.6	25.31	5.3
	Дүн	367,8	750.0	754,0

Эх материал: *ХААҮЯ, Сангийн сайдын 1998 оны а/66,129 тоот тушаал, гүйцэтгэлээр
 ** Усны аж ахуйн ерөнхий компани болит гүйцэтгэлийн мэдээгээр
 *** ХААҮЯ, ашигт малтмалын хэрэг эрхлэх газрын мэдээ
 ****3-5 дахь хэсгүүдэд бичсэн мэдээллийг
БОЯ-ны
 БОХА-ийн тайлан балансаас авав.

Сүүлийн хоёр жилд улс, орон нутгийн төсвөөс байгаль орчныг хамгаалахад олгож байгаа хөрөнгийн хэмжээг 60 хувиар нэмэгдүүлсэн бөгөөд 2000 онд 2889.4 сая төгрөг зориулахаар төлөвлөсөн байна. Энэ хөрөнгийн 57.7 хувийг улсын төвлөрсөн төсвөөс, 42.3 хувийг орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх юм. Орон нутгийн оролцогч талуудад буюу цөлжилттэй тэмцэх арга хэмжээнд зориулж байгаа улсын төсвийн хэмжээ нь байнгын санхүүжилт бөгөөд харин жилээс жилд есөн нэмэгдэж байна.

8.1.2 Гадаад, дотоодын нөөц бололцоог дайчлах арга, механизм

Цөлжилттэй тэмцэх ажлыг санхүүжүүлэх дараахь 2 төрлийн механизм

бий болоод байна.

Үүнд:

- Сан байгуулж цөлжилттэй тэмцэх арга хэмжээнд ашиглах.
- Үндэсний хуулийн хүрээнд байгалийн нөөц ашигласны төлбөрийн тогтолцоо бүрдүүлэх.

A). Цөлжилттэй тэмцэх сан

Байгаль орчныг хамгаалах, цөлжилттэй тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэхийн тулд дараах 2 төрлийн санг байгуулан ашиглаж байна.
Үүнд:

- “**Байгаль хамгаалах сан**” –г Засгийн газрын 1998 оны №188-дугаар тогтоолоор байгуулав. Байгаль хамгаалах сангаас тодорхой жижиг теслүүдийг шалгаруулан жил бүр санхүүжүүлж байна. 1997-1999 онд 43.6 сая төгрөгийн теслийг санхүүжүүлжээ.
- “**Байгаль орчны итгэмжлэгдсэн сан**” –г Даян дэлхийн байгаль орчны сан (GEF), НҮБ-ын Ган, цөлжилттэй тэмцэх алба (UNSO) –ийн дэмжлэгтэй байгуулав. “**Байгаль орчны итгэмжлэгдсэн сан**” –г бүрдүүлж түүний эх үүсвэрт энэ оны төвлөрсөн төсвөөс 1.6 тэрбум төгрөг¹ төлөвлөсөн байна. Итгэмжлэгдсэн сангийн шугамаар хуримтлагдах херенгэ нь үндсэндээ 2 төрлийн үйл ажиллагаанд буюу Монгол улсын биологийн төрөл зүйлийг хамгаалах, цөлжилттэй тэмцэх арга хэмжээнд зарцуулагдана. Энэ херенгийг оролцуулж тооцвол төв, орон нутгийн төсвөөс байгаль орчныг хамгаалах, цөлжилттэй тэмцэх арга хэмжээнд зарцуулах херенгэ 5.2 тэрбум төгрөг болох юм. Эдгээр сангийн дэмжлэгт газар зохион байгуулалтыг сайжруулах, бохирдлоос сэргийлэх, орчны доройтлыг багасгах, цөлжилттэй тэмцэх зэрээр тодорхой жижиг теслүүдийг дэмжих санхүүжүүлдэг.

Б). Үндэсний хуулийн хүрээнд байгалийн нөөц ашигласны орлогоос байгаль хамгаалах, цөлжилттэй тэмцэх арга хэмжээг санхүүжүүлж байна.

Байгаль хамгаалах цөлжилттэй тэмцэхэд зориулах херенгийг зах зээлийн орнуудын жишгийн дагуу байгалийн нөөц ашиглалтын төлбөрт тусгах замаар бүрдүүлдэг. Энэ асуудлыг байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжид тусган хэрэгжүүлж байгаа билээ. Тухайлбал:

- “**Ойн тухай**” хуулиар ойг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд төсвөөс зарцуулах херенгийн хэмжээг тухайн жилд мод бэлтгэн

- ашигласны төлбөрийн орлогын 70 хувиас багагүй байхаар тогтоосон “Газрын төлбөрийн тухай хууль”-д газрын төлбөрийн орлогын нилээд хувийг газар хамгаалах нөхөн сэргээх, цэлжилттэй тэмцэх арга хэмжээнд зарцуулж байх, уг хувь хэмжээг тухайн жилд авч хэрэгжүүлэх арга хэмжээ, төлбөрөөс орох орлогыг харгалзан Засгийн газраас тогтоон хэрэгжүүлж байхаар тогтоосон. 2000 онд газрын төлбөрөөс газар зохион байгуулалт, газрыг хамгаалах арга хэмжээнд 250.0 сая төгрөг олгохоор төлөвлөсөн нь дээрх төлбөрийн 16 хувьтай тэнцэж байна.
- Байгалийн ургамал ашигласны төлбөрт ноогдох 1сая төгрөгийг орон нутагт зориулалтаар нь ашиглана.
- Ус, рашаан ашигласны төлбөрийн орлогод 158.4 сая төгрөгийг төвлөрүүлж ус хамгаалах, усны орчинг сэргээхэд зориулахаар төлөвлөөд байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого бараг бүхэлдээ орон нутгийн тесевт хамарагдаж байгаа, түүнчлэн байгаль хамгаалах, байгалийн нөөцийг сэргээх үйл ажиллагааг ч тухайн газар нутгийг ашиглаж эзэмшиж байгаа иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгө хүчиний оролцоотойгоор авч явуулж байна.

Цэлжилттэй тэмцэх ажлын санхүүжилт, түүний менежментэд орон нутгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар дамжуулан оролцогч янз бүрийн талууд байнга оролцож, хяналт тавьж байх журам тогтоод байна.

В). Олон улсын байгууллагууд, хандивлагч орнуудтай хамтран ажиллаж байгаа нь

(а) Сүүлийн 4 жилд олон улсын байгууллага, хандивлагч орнуудтай ЦТК-ийн НБДГ, НУБХХ, НУБ-ын ЮНСО, НУБ БОХ, Данида, Жайка, GTZ, НУБ-ийн АНДЭЗНК, АХБ, ДБ зэрэг техникийн хамтын ажиллагааны шугамаар Монгол орны байгаль цаг уурын нехцэлд, нүүдлийн мал аж ахуй эрхлэдэг технологийн онцлогийг судлан үзээд түүний менежментийг сайжруулах, газрыг зохистой ашиглах, хамгаалахад чиглэсэн хэд хэдэн тесел хэрэгжүүлсэн буюу хэрэгжүүлэх шатандаа явж байна. Эдгэр теслүүдийн талаар 6 дугаар хэсэгт тодорхой оруулсан болно.

(б) Дэлхий дахинь механизмын хувь нэмэр

Монгол орны хуурай нутгийн цэлжилттэй тэмцэх арга хэмжээнд ЦТК-ийн дэлхий дахинь хэмжээний мөханизмээс одоогоор ямар нэг хувь нэмэр оруулаагүй болно.

8.1.3 Хуурай гандуу нутгийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын дүн шинжилгээ

Хуурай гандуу нутгийг усжуулах

Монгол орны цэл, целерхөг хээрийн хуурай бүс нутаг нь газар орны байршил хийгээд уур амьсгалын удаан хугацааны өөрчлөлтийн үр дүн бөгөөд биологийн системүүдийн тогтвортгүй, бүтээмж багатай орчинд хамарагддаг.

Энэ хуурай гандуу нутгийн бэлчээрийг олон мянган жилийн турш нутгийн угуул нүүдэлч-малчид ашиглаж, мал аж ахуй хөгжүүлж ирсэн уламжлалтай.

Бэлчээрийн ургац нь үндсэндээ тухайн жилийн нийлбэр тунадасны хэмжээ, хуваарилалтаас шуд шалтгаалдаг юм. Монголын хуурай бүс нутагт жилдээ 50-200мм тунадас унаж байгаа нь ууршицаас 20 - 4 дахин бага байх бөгөөд үүнээс шалтгаалж байнгын чийгийн хомсдолыг нехцэлдүүлж ургацын хэмжээг хязгаарладаг.

Бэлчээрийн ургамлын даацыг хэтрүүлэн ашиглаж байгаа нүүдлийн мал аж ахуйн өнөөгийн байдал нь газрыг доройтолд оруулж, экологийн хувьд онцгой ач холбогдол бүхий цөөн хэдэн горхи, худгийн ойролцоо хэсэг хэсэг толбо маягийн цөлжилтийн голомт үүсгэж байгаа нь тогтоогдсон юм.

Ийм учраас Засгийн газраас ашиглагдаагүй байгаа бэлчээр нутагт мал бэлчээрлүүлэхийн тулд худаг, уст цэгийг олшууллах бодлого боловсруулж "Монгол Улсын усны үндэсний хетелberийг" хэрэгжүүлж байна.

Хетелberийн хүрээнд эхний эзлжинд урьд өмнө гарган ашиглаж байсан худгуудыг сэргээн, шинэчлэх зардалд суулийн 2 жилд 522,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж 337 худгийг ашиглалтад оруулсан байна. (Хүснэгт 2) Энэ арга хэмжээг хэрэгжүүлснээр 1,07сая малын усан хангамж бэлчээр, тэжээлийн нехцэл сайжирна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөс малчдад зориулан бага гүнд тохиолдох өнгөний ус ашиглах малтмал худаг 3000 орчмыг гаргаж 40 орчим сая төгрөг зарцуулсан байна.

Ойжуулалт

Ойжуулалтанд нилээд түлхүү анхаарч үр ашигаа өгөх үйл ажиллагааны төрөл гэж үзэж байгаа нь оруулж байгаа хөрөнгөөс харагдаж байна. (Хүснэгт2)

Монгол орны ойг нехен сэргээх, ойжуулах ажлаар 1997 онд 5001.1 мянган га-д 1998 онд 5299.6 мянган га-д 1999 онд 5005.0 мянган га-д ойжуулалтыг хийж гүйцэтгэсэн бөгөөд 2000 онд нийт 10.000 мянган га-д ойжуулалт хийхээр төлөвлөөд байна.

Ойжуулалтын ажилд 1997 онд 120,3 сая төгрөг, 1998 онд 119,7 мянган төгрөг, 1999 онд 180.0 мянган төгрөгийг зарцуулав.

Ойн хөнөөлт шавьж, өвчинтэй тэмцэх ажлыг 1997 онд 2400 га талбайд, 1998 онд 2250 га талбайд явуулсан байна.

1999 онд нийт 9092 га талбайд ойн хөнөөлт шавьжийн устгал хийлээ.

Ойн хөнөөлт шавж, ёвчний судалгаа тэмцлийн ажилд 1997 онд 8,2 сая, 1998 онд 4,1 сая, 1999 онд 68,0 сая төгрөг тус бүр зарцуулаа.

Хуурай гандуу бус нутагт байгуулж буй дэд бутэц үйлдвэр уурхай

Хуурай бус нутгийн дэд бутцийг сайжруулах зорилгоор Дундговь, Өвөрхангай, Дорноговь аймгийн таван сумдыг төвийн эрчим хүчиний системд холбох ажлын дутууг гүйцэхээс /1.8млрд төг/ гадна, 2000 онд шинээр 4 аймгийн 4 сумын төвийг эрчим хүчиний системд холбох ажлыг эхлэхэд 2.2 тэрбум төгрөг төлөвлөөд байна. Цахилгаан хангамжийн бэрхшээлтэй Говь хээрийн бүсийн найман аймгийн 25 сумын төвд бага оврын дизель цахилгаан станц суурилуулах ажлыг гүйцэтгэх юм. Мөн эмнэлэг сургууль мэтийн чухал объектуудыг нар, салхины эрчим хүч хослосон цогцолбороор гэрэлтүүлэх ажлыг хийж байна.

9. ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦЫГ ТОДОРХОЙЛОХОД АШИГЛАСАН ШАЛГУУР БОЛОН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ТАЛААРХИ ТОЙМ .

9.1 Байгаль орчны мониторинг, үнэлгээний шуурхай механизм

9.1.1 Байгаль орчны мониторингийн үндэсний чадавхийг бэхжүүлэх нь Газар нутгийн доройтол, цөлжилтийн тархалт, хурдацыг тодорхойлж серег үр дагаврыг эрт илрүүлэн сэргийлэх, газрын нөөцийг зохицой ашиглах, улмаар цөлжилттэй тэмцэх, экологийн таатай орчин үүсгэх зорилгод нийцуулэн үндэсний байгаль орчны мониторингийн чадавхийг бий болгох талаар тодорхой алхам хийгдлээ.

Байгаль орчны мониторингийн чадавхийг бий болгоход дараахи чиглэлээр ахиц гарав. Үүнд:

a. Мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, сургах, давтан сургах

МУИС, УБИС, ХААИС-д газарзүйч, биологич, геоботаник, зоолог, газар зохион байгуулагч, цаг уурч, ус зүйч, экологич, ой зүйч, агрономич мэргэжлээр дотоодоо жил бүр 50-60 мэргэжилтэн бэлтгэн гаргаж байна. Сүүлийн жилүүдэд гадаадад бэлтгэх мэргэжилтний тоо цөөрсөн хэдий ч байгаль орчны чиглэлээр магистрантурт суралцах нь ихсэж байна.

Мен байгаль орчны чиглэлээр дагнасан сургалт явуулах "ЭКО-АЗИ" коллеж байгуулагдан ажиллаж эхэллээ.

Орон нутагт ажиллаж буй байгаль орчны хамгаалагч болон тусгай дунд боловсролтой газар зохион байгуулагчдыг эчнээс сургалт, курсээр мэргэжлийг нь дээшлүүлж байна. Ялангуяа байгаль хамгаалагчдыг Монголын дархан газрын нийгэмлэг хариуцан мэргэжлийг нь дээшлүүлэх боллоо.

БНХАУ-ын Ланьчжу хотын Цэл судлалын хүрээлэн, Израиль улсын Якоб Блауштайны нэрэмжит Цэл судлалын хүрээлэн, Энэтхэг улсын Гандуу нутгийн эрдэм шинжилгээний хүрээлэн (Рожастан муж)-гүүдэд байгаль орчны чиглэлийн мэргэжилтэн, эрдэм шинжилгээний ажилтнууд тодорхой хугацаагаар очиж олон улсын курст суралцан мэргэжил дээшлүүлж байна.

b. Мэдээллийн хэрэгсэл, тоноог төхөөрөмж бий болгох

Байгаль орчны мэдээллийн системийн эх суурь 1972 онд тавигдсан. БОЯ-ны Мэдээлэл тооцооллын төв нь улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж улмаар Новосибирск, Бээжин хотуудад байрлах

тэвийн бүсүүдээр дамжуулан Дэлхийн цаг уурын байгууллагын цахилгаан холбооны сүлжээгээр мэдээлэл хүлээн авах, солилцох, дамжуулах, цаашилбал Засгийн газар, нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, телевизийн өргөн нэвтрүүлэг, нисэхийн байгууллагад эх орны болон дэлхийн цаг агаарын тухай мэдээллийг тогтмол хүргэх, хиймэл дагуулаас мэдээлэл хүлээн авах, боловсруулах чиглэлээр ажиллаж, Тандан судалгааны үндэсний зохицуулах тэвийн үүргийг гүйцэтгэж байна.

Ус цаг уурын болон байгаль орчны мэдээлэл солилцох энэхүү сүлжээ нь Монгол улсын нутаг дэвсгэрийг хамарсан 24 цагийн үйл ажиллагаатай цорын ганц компьютерийн глобаль сүлжээ юм. Уг сүлжээний цахилгаан холбооны шугамыг МЦХК-аас түрээсэлдэг.

БОЯ-ны Ус цаг уурын хүрээлэн нь цаг уурын мэдээллийн дотоод болон гадаад сүлжээг ашиглан мэдээг хүлээн авч боловсруулан хэрэглэгчдэд түгээж байна. Дэлхийн хиймэл дагуулын TOVS мэдээг хүлээн авч ашиглан агаарын янз бүрийн үе давхаргын даралт, температур, салхи, чийгшлийн оронг сэргээж, Дэлхийн цаг уурын байгууллагын бүсийн болон төрөлжсөн төвүүдээс хойд хагас бөмбөрцөгийн даралтын орны прогнозын GRID мэдээг ашиглан хоногийн их, бага температур, хагас хоногийн хур тунадасны прогнозыг гаргаж байна.

БОЯ-ны Мэдээлэл тооцооллын төв анх 1970 оноос эхлэн хиймэл дагуулаас зурагт мэдээлэл хүлээн авч улмаар дурсэн болон тоон мэдээлэл хүлээн авах, боловсруулах системийг 1985 онд суурилуулж 1997 онд шинэчилсэн байна. Одоо тус төв НОАА хиймэл дагуулаас мэдээ хүлээн авах системээр өдөрт 6 удаа мэдээг хүлээн авч боловсруулан байгаль орчны төлөв байдлын мониторингийн зориулалтаар ашиглаж байна.

ШУА-ийн Информатикийн хүрээлэнгийн Геоинформатикийн лаборатори сансрын "Союз Т4 - Солют 6 - Союз 39" цогцолбороос авсан олон бүсчлэлийн зурагт боловсруулалт хийж бэлчээр, хөрс, ургамалжилтын тухайн төлөв байдлыг шинжлэн судлахад ашиглаж суурь зурган мэдээлэл бэлтгэсэн байна.

Тус төвд НҮБХХ-ийн хүрээнд "ERDAS 7.5" системийг суурилуулсан нь олон бүсчлэлийн өндөр нарийвчлалтай дагуулын дүрст тоон мэдээлэлд цогц анализ хийх бололцоотой болсон. 1997-1998 онд Германы мэргэжилтнүүдтэй хамтарч ERS-1; 2 дагуулаас радиометрийн SAR мэдээлэл хүлээн авах газрын станцыг суурилуулснаар байгаль орчны төлөв байдлын судалгаанд шинэ алхам нээгдэж байна.

9.1.2 Цэлжилттэй тэмцэх мэдээллийн сан. Монгол улсад өнөөдөр Цэлжилттэй тэмцэх үндэсний хорооны мэдэлд ажиллах цэлжилттэй тэмцэх мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоо жинхэнэ утгаараа

бүрдэж чадаагүй хэдий ч байгаль орчны төрийн ба төрийн бус байгууллагын мэдээллийн сангаас цөлжилт, байгалийн гамшигийн талаар мэдээлэл авах, дүн шинжилгээ хийх, судалгаа явуулахад холбогдох мэдээллийг цаг тухайд нь авах бүрэн боломжтой.

Цөлжилтийн холбогдолтой мэдээллийн ихэнхи нь енеедер БОЯ-ны харьяа байгууллагууд, тухайлбал тус яамны номын сан, Мэдээлэл тооцооллын төв, Ус цаг уурын хүрээлэн, Газар зохион байгуулалтын алба, Байгаль орчныг хамгаалах албанад төвлөрч байна. Түүнээс гадна ШУА-ийн Газарзүй, Геоэкологи, Ботаник, Биологи, Информатикийн хүрээлэн болон МАА-н хүрээлэн, Улсын геодези зурагзүйн газар, ХААҮЯ-ны Гео мэдээлэл, тандан судалгааны төвд холбогдох мэдээллүүд байна.

Улсын Геодези Зурагзүйн газрын агаар сансрын зураг боловсруулах лабораторид монгол орны нутгийг бүрхсэн 1:45000, 1:32000 масштабын агаарын гэрэл зураг, мөн сансрын болон агаарын олон бүсчлэлийн зургийн негатив, позитив хальс, байрзүйн зураг хадгалагдаж байдаг. Эдгээр агаар, сансрын зураг болон байрзүйн зургаар байгууллага, хэрэглэгчдийн захиалгыг авч үйлчилж байна. Цаашид тоон аргаар байрзүйн зураг зохиох, хэвлэх технологи нэвтрүүлэх, энэ чиглэлд газарзүйн мэдээллийн тогтолцоо (GIS) байгуулах бэлтгэл ажил хангаад байна.

ШУА-ийн Газарзүй, Ботаник, Геоэкологийн хүрээлэнд газар, ус, ой, ан амьтан, ургамал зэрэг байгалийн неөөцийн, хүн ам, мап аж ахуй, нүүдэлч малчдын нийгмийн болон цөлжилтийн судалгааны холбогдолтой мэдээ, материал, зураг, зөвлөмж, диссертаци, ном, өгүүлэл, эрдэм шинжилгээний тайлан хадгалагдаж байна.

Байгаль орчны аливаа асуудлыг богино хугацаанд олон талт дүн шинжилгээ хийж шинжлэх ухааны үндэслэлтэй шийдвэрлэхэд байгаль орчны төлөв байдал, шинж чанар, неөөц, өөрчлөлт, ашиглалтын мэдээ, мэдээллийг бүрэн агуулсан мэдээллийн сан чухал үүрэг гүйцэтгэдэг.

БОЯ-наас энэ асуудалд онцгой анхаарч төсөл хэрэгжүүлсэн билээ. Уг төслийн хурээнд енөөдөр байгаль орчны мэдээллийн сангийн эхний хувилбар бий болоод байна. Уг сан дараахи үндсэн хэсгүүдээс бүрдэж байна.

Байгаль орчны болон цөлжилттэй тэмцэх үйл ажиллагааны мэдээллийн тогтолцоог дараахи байдлаар ангилж байна. Үүнд:

- Байгаль орчны (цөлжилтийн) мэдээллийн сан
- Газрын зураг, мэдээлэл
- Ном, хэвлэл

A. Байгаль орчны (цөлжилтийн) мэдээллийн сан

Энэхүү мэдээллийн сан нь дотроо дараах үндсэн хэсгүүдтэй.

Үүнд:

- Байгаль орчны ерөнхий мэдээллийн сан
- Байгаль орчны статистик мэдээллийн сан
- Байгаль орчны дэд сан
- Зурган мэдээллийн сан (GIS)

Эдгээрийг тус бурд нь авч үзье.

Байгаль орчны ерөнхий мэдээллийн сан

Энэ санд байгаль орчны төлөв байдал, шинж чанар, неөц, өөрчлөлт, ашиглалтыг Монгол орны хэмжээнд харуулах суурь мэдээ болон ерөнхий үзүүлэлтүүдийг оруулав. Энэ санг интернэтээр дамжуулан нийтэд хүргэдэг.

Байгаль орчны статистик мэдээллийн сан

Энэ нь байгаль орчны неецийн өөрчлөлт, ашиглалт, нехэн сэргээлттэй холбоотой 217 үзүүлэлт бүхий мэдээллийн сан юм. Эх мэдээг жил бүр аймгуудаас авдаг байгаль орчны тайлан, статистик мэдээгээр бүрдүүлж байна. Тухайлбал, Монгол орны газрын сангийн ашиглалтыг зориулалтаар нь ангилан түүний хэмжээ ба чанарын өөрчлөлтийн тухай мэдээллийг жил бүр сум, хороо, аймаг, хотоор авч улсын хэмжээнд нэгтгэн байгаль орчны жил тутмын тайландаа тусган мэдээллийн санд оруулж байна.

Байгаль орчны дэд сан

Өнөөдрийн байдлаар дараахи дэд сангуудыг байгуулаад байна.

Үүнд:

- Байгаль орчны төлөв байдал, чанар, бохирдол
- Ургамал, амьтан
- Ой
- Хөрс
- Гадаргын ба гүний ус
- Тусгай хамгаалалттай газар нутаг
- Байгалийн гамшигт үзэгдэл
- Стандарт, норм
- Хууль, эрх зүй
- Байгаль орчны салбарын байгууллага, эрдэмтдийн сан

Зурган мэдээллийн сан (GIS)

Зураг, газрын зургуудыг компьютерт оруулж тоон хэлбарт хөрвүүлэн энэ ажлыг гүйцэтгэв. Энээгийн байдлаар 1:1000000 масштабаар дор дурдсан зургуудыг мэдээллийн санд оруулж GIS байгуулаад байна.

Үүнд:

- Экосистем
- Ой
- Ландшафт
- Геологийн бүтэц
- Тэжээлийн нөөц
- Хадлан бэлчээр
- Гүний усны нөөц
- Хөрс
- Засаг захирагааны хил

Эдгээрт боловсруулалт хийж GIS-ийг цаашид хөгжүүлэх ажил байна.

Б. Газрын зураг, мэдээлэл

Монгол улс 1990 онд байгаль орчин, хүн ам, аж ахуйн 280 гаруй газрын зураг, зүсэлт, бүдүүвчийг агуулсан 45x60 см-ын хэмжээтэй 172 хуудас бүхий "Үндэсний атлас"-ыг хэвлэн гаргасан. Энэхүү атлас нь байгаль, нийгэм, эдийн засгийн бүх зургийг зэрэгцүүлэн дун шинжилгээ хийх замаар тус оронд нутаг дэвсгэр-үйлдвэрлэлийн болон газарзүйн тогтолцооны бурзэлдэн тогтсон одоогийн төлөв болон цаашид хувиран вөрчлөгдхөд зүй тогтолыг илрүүлэх боломж олгож байгаад түүний шинжлэх ухааны ач холбогдол оршино.

- Манай эрдэмтэд 1979 онд монгол орны ургамалжилтийн зураг 1:1500000, 1981 онд хөрсний зураг 1:2500000, 1986 онд ойн хэв шинжийн зураг 1:1500000 зэрэг масштабтай зургуудыг зохиож гаргасан нь цэлжилттэй тэмцэх болон байгаль хамгааллын арга хэмжээ төлөвлөхөд өргөн ашиглаж байна.
- 1981 онд сансрын зураг мэдээлэл ашиглан монгол орны хадлан бэлчээр, хөрс ашиглалт, ландшафт типологи, газрын сан, ойн сан, геологи-структур, гадаргын ба газар доорхи усны нөөц зэрэг сэдэвчилсэн 9 зургийг 1:1000000 масштабаар зохиож хэвлүүлсэн байна.
- 1995 онд Монгол орны экосистемийн зургийг, 1999 онд геологийн зургийг тус тус саятын масштабаар хэвлэн гаргалаа. Эдгэрээс экосистемийн зурагт 399 экосистемийг ангилж, түүнийг эвдрэлийн

зэрэглэлээр ялган харуулсан нь целжилтийн мониторинг судалгаанд гол хэрэглэх бүтээл болж чадсан юм.

В. Ном, хэвлэл

Байгалийн нехцөл, байгаль орчны өөрчлөлт, байгаль хамгааллын чиглэлээр жил бүр 10 орчим ном хэвлэгдэн гарч байгаагаас гадна "Уяхан замбуу тив", "Тогтвортой хөгжил", "Байгаль орчны мэдээлэл", "Шинжлэх ухаан амьдрал", "Түмэн бодис" зэрэг сэтгүүл "Байгаль", "Тогтвортой хөгжил" зэрэг сонин тогтмол хэвлэгдэн гарч байна.

9.1.3. Одоо байгаа механизм, бүтэц, тогтолцоог нийцүүлэх арга хэмжээ БОЯ-ны харьяанд тохируулагч агентлаг болох Газар зохион байгуулалтын алба, Байгаль орчны хамгаалах алба болон Газрын кадастрын лаборатори, аймгуудын Засаг даргын тамгын газарт Газрын харилцааны алба, ШУА-ийн Геоэкологийн хүрээлэнд Цэлжилттэй тэмцэх үндэсний төвийг тус тус шинээр байгуулав,

Цэлжилттэй тэмцэх чиглэлийн судалгааг БОЯ-ны харьяа Мэдээлэл тооцооллын төв, Ус, цаг уурын хүрээлэн, ШУА-ийн Газарзүй, Геоэкологи, Ботаникийн хүрээлэн төслийн хэлбэрээр явуулж үр дүнг ЦТҮХор болон БОЯ-ны хэрэгжүүлэх агентлаг болох Газар зохион байгуулалтын алба, Байгаль орчны хамгаалах албандаа шилжүүлж байна.

Мөн БОЯ-ны харьяа Байгаль орчны шинжилгээний төв лаборатори, ШУА-ийн хүрээлэнгүүдэд хөрсний, усны, химиийн, ургамалын физиологийн, Геомэдээллийн зэрэг лабораториуд ажиллаж, шаардлагатай судалгаа шинжилгээг хийж байна.

9.1.4. Гол оролцогч талуудын мэдээлэл олж авах боломж. Гол оролцогч талуудад БОЯ, түүний харьяа байгууллагууд, ШУА, түүний харьяа хүрээлэнгүүд болон териийн бус байгууллагууд, хувийн хэвшлийн аж ахуй, байгаль орчны нелеөөллийн үнэлгээний эрх бүхий хувийн компаниуд орох бөгөөд өөр хоорондоо мэдээлэл солилцох, үйлчилгээний механизм бурдээгүй байна. Дээрхи оролцогч талууд компютерийн дотоод сүлжээ, интернет, и-мэйлийн сүлжээнд холбогдоод байна. Одоогийн нехцөлд хэрэгцээт мэдээллийг байгууллага, эрдэмтэд боловсруулан гаргаж дискетээр дамжуулах систем үйлчилж байна.

9.1.5. Дүн шинжилгээний үр дүнг зөвлөлдөх механизмын Цэлжилт, байгалийн гамшгийн хор холбогдлыг үнэлж, тэдгээрээс урьдчилан сэргийлэх, сэргээн сайжруулах арга хэмжээ авах, эрч далайц.

тархалтын хүрээг судлах, гадаад дотоодын тусламж, төсөл хэрэгжүүлэх асуудлыг эрдэм шинжилгээний хурал, семинар, БОЯ-ны Сайдын зөвлөлийн хурал, БОЯ-ны Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн хурал, Цэлжилттэй тэмцэх үндэсний хорооны хурал болон Засгийн газрын хуралдаанаар авч хэлэлцэж зохих шийдвэр гарган ажиллаж байна.

- **Эрдэм шинжилгээний бага хурал.** Өнгөрсөн хугацаанд "Даян дэлхийн өөрчлөлт-говь, цөл", "Даян дэлхийн өөрчлөлт-Увс нуур", "Байгалийн гамшгийг бууруулах асуудал", "Монголын тэгш өндөрлөгийн экосистемийн өөрчлөлт", "Төв Азийн гандуу бус нутгийн уур амьсгалын өөрчлөлт" зэрэг олон улсын болон дотоодын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулж судалгааны үр дүн болох олон арван илтгэл хэлэлцсэн байна.
- **Үндэсний семинар.** 1995, 1997 онд НҮБХХ, ЮНСО, НҮБ-ын Цэлжилттэй тэмцэх конвенцийн Нарийн бичгийн дарга нарын газартай хамтран Улаанбаатар хотод Цэлжилттэй тэмцэх үндэсний семинарыг зохион байгуулж, сургалт явуулан ЦТҮХ-ийг боловсруулах үнэлгээ өгөх, хэрэгжүүлэх талаар бодитой алхам хийж төр, засаг, олон нийтэд хандаж уриалга гаргасан байна.
- **Цэлжилттэй тэмцэх үндэсний хороо** жилд 3-аас доошгүй удаа хуралдаж ажлын төлөвлөгөө, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, цөлжилт эрчимжсэн газарт гүйцэтгэж буй гэрээт ажил, шинэ тесел хэрэгжүүлэх асуудал, жижиг төслийн үр дүн зэрэг асуудлыг авч хэлэлцэн зарим асуудлыг БОЯ-ны сайдын зөвлөлийн хуралд оруулж шийдвэр гаргуулсан байна.

9.1.6. Тогтмол тайлагнах байдал. ЦТК болон ЦТҮХ-ийн биелэлтийг жил бүр гаргаж БОЯ-ны сайдын зөвлөлд тайлагнах журам тогтолоо. Харин ЦТК-ын үндэсний тайланг Талуудын анхдугаар Бага хурлаас (ТБХ) гаргасан шийдвэр ТБХ/11-ийн дагуу 2000 онд анх удаа бэлтгэн Монгол улсын засгийн газар, ЦТК-ын НБДГ-аар дамжуулан ЦТК-ын Талуудын 4-р Бага хуралд оруулаад байна.

9.1.7. ЦТҮХ-ны менежментийн үнэлгээний талаар гаргах санал. БОЯ болон Цэлжилттэй тэмцэх үндэсний хороо, Мэдээлэл тооцооллын төвтэй компьютерийн дотоод сүлжээгээр холбогдож байгаль орчны мэдээллийн нэгдсэн тогтолцооны эхний алхам бүрдээд байна. Цаашид терийн бус байгууллага, шинжлэх ухааны суурь судалгаа явуулдаг хүрээлэн, төвүүдтэй байгаль орчны мэдээлэл хүлээн авах, боловсруулах, хэрэглэгчдэд хүргэх, дүнэлт, шийдвэр гаргах түвшинд хүртэл хамтран ажиллах шаардлагатай байна.

Мен цөлжилтийн чиглэлээр судалгаа явуулдаг хүрээлэн, төв, лабораториудад тоног төхөөрөмж, багаж материалын хомсдол их байна. Хөрөнгө санхуугийн бэрхшээлээс болоод доройтсон орчныг нэхэн сэргээх ажил хийгдэхгүй байна. Үүний зэрэгцээ үндэсний мэргэшсэн боловсон хүчний чадавхийг бүрдүүлэхэд шинэлэг бөгөөд дорвитой ажил хийгдэхгүй байна. Эдгээр асуудалд онцгой анхаарснаар цөлжилттэй тэмцэх нэгдсэн менежмент сайжирч үр дүнд хүрэх болно.

Хавсралт 1

Цөлжилттэй тэмцэх үндэсний хорооны бүрэлдэхүүн

(Байгаль орчны сайдын
1998 оны 59 дүгээр тушаалаар)

Зөвлөлийн дарга	Ц.Адъяасүрэн	Байгаль орчны сайдын зөвлөх
Дэд дарга	Н.Сарантуяа	БОЯ-ны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга
Нарийн бичгийн дарга	Д.Даш	ШУА-ийн Геоэкологийн хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга
Гишүүд:	З.Батжаргал	Ус цаг уур орчны шинжилгээний газрын дарга
	Н.Эрдэнэсайхан	БОЯ-ны Хамтын ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн
	Ч.Дагвадорж	ЭМНХЯ-ны Стратегийн бодлого, удирдлага, төлөвлөлт газрын мэргэжилтэн
	Х.Жалбаа	ШУА-ийн Геоэкологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан "Хөгжил ба орчин төв" төрийн бус байгууллагын Еренхий нарийн бичгийн дарга
	А.Намхай	Газрын кадастрын лабораторын эрхлэгч
	Р.Ганхуяг	Монгол улсын 20 дугаар зууны тогтвортой хөгжлийн хетелбер төслийн үндэсний зохицуулагч
	Б.Хулдорж	ШУА-ийн Геоэкологийн хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга
	С.Чулуунхуяг	

Хаяг: Бага тойруу-44. Засгийн газрын 3-р байр

Өрөө: 518, 403

Утас: 312458, 322830

Факс: 312320

Ашигласан хэвлэл

1. Монгол улсын үндсэн хууль, УИХ, 1992
2. Монгол улсын үндэсний хөгжлийн үзэл баримтлал, УИХ, 1996
3. Төрөөс экологийн талаар баримтлах бодлого, УИХ, 1997
4. Монгол улсын 21-р зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр, УБ, 1999, 297 хуудас
5. Целжиттэй тэмцэх үндэсний хөтөлбөр, УБ, 1997, 71 хуудас
6. Ойн тухай үндэсний хөтөлбөр, МУ Засгийн газар 1998
7. Усны үндэсний хөтөлбөр МУ-ын ЗГ
8. Байгалийн гамшгийг бууруулах үндэсний хөтөлбөр МУ ЗГ
9. Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр, УИХ 1998
10. Байгаль орчны үйл ажиллагааны үндэсний хөтөлбөр, МУ ЗГ, 1994
11. Монгол орны биологийн төрөл зүйлийг хамгаалах үйл ажиллагааны үндэсний хөтөлбөр, УБ, 1997, 165 хуудас
12. Хог хаягдлыг бууруулах хөтөлбөр, МУ ЗГ, 1998
13. Монгол улсын Байгаль орчны хууль, УБ, 1996, 151 хуудас
14. Mongolian Economy and Society in 1999, Statistical Yearbook, UB, 1999.
15. Some aspects to combat desertification in Mongolia., Edited by Adyasuren Ts. Borjigdkhan, UB, 1999, 127 page.
16. Adyasuren Ts. Environment & Development issies in Mongolia, UB, 1998., 96 page.
17. Adyasuren Ts. Sangidansranjav S, Combating desertification in Mongolia, UB, 1997.
18. The international Expert Group meeting of the preparation of the Regional Action Programme for combating Desertification and Drought in Asia, Bangkok, 1998, 124 page.